

ТАЛАРХАЛ

Энэхүү судалгааг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлсэн Авлигатай тэмцэх газарт талархал илэрхийлье. Түүнчлэн бидний судалгаанд цаг заваа харамгүй зориулан үзэл бодлоо хуваалцсан Улаанбаатар хотын хүн амын амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн иргэд, Нийслэлийн Багахангай, Багануур, Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар, Налайх дүүргийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсийн удирдлагууд, эдгээр дүүргийн Хүнс тэжээлийн дэмжлэг туслалцаа хариуцсан мэргэжилтнүүд, Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн 2 дугаар хэлтсийн Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба, Эрүүл хамгаалалт хариуцсан тасгийн хамт олон болон Эрүүлжүүлэх, саатуулах байрны алба хаагч нарт, Хан-Уул дүүргийн цагдаагийн 1 дүгээр хэлтсийн Нийтийн хэв журам хамгаалах тасгийн Эрүүл хамгаалалтыг хариуцсан чиглэлийн хамт олонд гүнээ талархал илэрхийлж байна.

Энэхүү судалгааны асуулга болон үр дүн, дүгнэлт, санал зэрэг нь зөвхөн тухайн судалгааны багийн судалгааны үр дүн бөгөөд Авлигатай тэмцэх газар албан ёсны байр суурь, бодлогоор нөлөөлөөгүй болно.

СУДАЛГААНЫ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Судалгааны багийн ахлагч:

О.Нэмэхханд, ДХИС-ийн ХАС-ийн Сэтгэл зүйн тэнхимийн эрхлэгч, доктор, профессор

Судалгааны багийн зөвлөх:

О.Баасанхүү “Дэлгэрэнгүй хууль” ТББ-ын захирал

Судалгааны багийн гишүүд:

- Э.Номинтуяа, “Дэлгэрэнгүй хууль” ТББ-ын гүйцэтгэх захирал
- З.Одзаяа, ДХИС-ийн ЭЗНУС-ийн Нийгмийн ухааны тэнхимийн ахлах багш
- Г.Маралгоо “Дэлгэрэнгүй хууль” ТББ-ын мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн
- Д.Жаргалмаа “Дэлгэрэнгүй хууль” ТББ-ын бичиг хэрэг хариуцсан ажилтан
- Б.Нармандах, “Дэлгэрэнгүй хууль” ТББ-ын судалгааны ажилтан
- Э.Номинцацрал “Дэлгэрэнгүй хууль” ТББ-ын судалгааны ажилтан
- Ж.Маргад-Эрдэнэ “Дэлгэрэнгүй хууль” ТББ-ын судалгааны ажилтан
- Т.Энхчимэг “Дэлгэрэнгүй хууль” ТББ-ын судалгааны ажилтан
- Б.Дөлгөөн, Г.Урангоо “Дэлгэрэнгүй хууль” ТББ-ын туслах ажилтан

БҮЛЭГ 1: СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1.1. СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА

Судалгааны ажлын үндэслэл

Монгол улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 болон Тогтвортой хөгжлийн зорилтуудад тодорхойлсон үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг хөгжүүлэхэд хөгжлийн бодлогоо бүх төвшинд хэрэгжүүлэх чадвартай, “Авлигаас ангид, иргэдийн оролцоог хангасан, мэргэшсэн тогтвортой засаглал төлөвшсөн байна”¹ гэж заажээ.

Авлигаас ангид, иргэдийн оролцоог хангахад тэдний эрүүл, аюулгүй орчин, эдийн засгийн хараат бус байдлыг хангаж, нийгмийг хөгжүүлэх хөтөлбөр, төслийн үйл ажиллагаандаа иргэдийн оролцоог дэмжиж, “Хүн амын амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн иргэдийн идэвхтэй оролцоог хангах нь чухал билээ. Гэтэл “Ковид-19” цар тахал Монгол Улсад нүүрлээд 2 жил болж байгаа бөгөөд түүний уршгаар хүн амын эрүүл мэнд, эдийн засгийн салбарт амаргүй, хүнд бэрх асуудлууд тулгарч байгаа юм. Энэ нь нийслэлийн хүн амын “Зорилтот бүлэг”-ийн халамжийн хүнсний эрхийн үйлчилгээнд хамрагддаг амьжиргааны түвшин тогтоох судалгаагаар 292,5 ба түүнээс доош оноотой иргэдийн ахуй амьдрал улам бүр эмзэг болж архидах, гуйлга гуйх, гэмт хэрэг үйлдэх, улмаар сэтгэц эмгэгийн тархалт огцом ихсэж байна.

Монгол Улсын Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр бүлэг, 18.1.3. дүгээр заалт “авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгааныг 2 жилд нэгээс доошгүй удаа судлан авлигын индексийг гаргаж олон нийтэд мэдээлэх” заалтыг хэрэгжүүлэх, мөн “Дэлгэрэнгүй хууль” төрийн бус байгууллагаас Авлигатай тэмцэх газарт нийлүүлэх тусгай захиалгат бүтээгдэхүүн болох Нийслэлийн хүн амын “зорилтот бүлгийн” авлигын талаарх ойлголт, хандлагын талаар судалгаа хийх, мэдээллийн санг шинэчлэх” ажлуудыг үндэслэл болгов.

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО:

“Нийслэлийн хүн амын амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн иргэдийн авлигын талаарх ойлголт, хандлагыг тодорхойлох судалгаа хийж, тэдний сэтгэл зүйн онцлог, харилцааны хүрээнд оношлон тодорхойлж, Авлигын эсрэг бодлого боловсруулагч байгууллагууд болон бусад хэрэглэгчдийг мэдээллээр хангах явдал юм.

ЗОРИЛТ:

Энэхүү үндсэн зорилгын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Авлига, түүний нөхцөл байдал, “Зорилтот бүлгийн иргэд”-ийн сэтгэл зүйн онцлог, харилцааны хүрээнд оношлон тодорхойлж, сэтгэцийн үзэгдлийг судалгааны үр дүнтэй харьцуулан судлах;
- Нийслэлийн хүн амын амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн иргэдийн авлигын талаарх ойлголт, хандлагыг тодорхойлж, үнэлгээ хийх;
- Нийслэлийн хүн амын амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн иргэдийг авлигын асуудлаас сэргийлэхэд чиглэсэн бодлого, орчныг боловсронгуй болгох санал, зөвлөмж боловсруулах;

СУДАЛГААНЫ ХЯЗГААРЛАГДМАЛ БАЙДАЛ

¹ <https://www.legalinfo.mn/annex/details/> Алсын хараа-2050

Уг судалгаа дараах хязгаарлалтуудыг өөртөө агуулсан болно. Үүнд:

1. Нийслэлийн Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсийн “Амьжиргааны түвшин тогтоох судалгаагаар 292.5 ба түүнээс доош оноотой иргэд”-ийн бүртгэл, мэдээлэл тусгагдаагүй.
2. “Нийслэлийн хүн амын амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн иргэд”-ээс судалгаа авахдаа 18 буюу түүнээс доош насны, 70 буюу түүнээс дээш насны иргэдийг хамруулаагүй.
3. Монгол Улсын “Хүн амын амьжиргааны доод түвшин тодорхойлох тухай” хуулийн 3 дугаар зүйлд зааснаар² бид тус судалгааныхаа тодорхой хувийг “Халамжийн хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг Улаанбаатар хотын 7 дүүргийн иргэдийг, түүнчлэн 2 дүүргийн цагдаагийн байгууллагын бүртгэл хяналтад байдаг согтуурах, мансуурах донтой хүмүүсээс, мөн тодорхой оршин суух хаяггүй иргэдийг хамруулсан.
4. Нийслэлийн зарим дүүргийн эмнэлэг, болон өрхийн эмнэлгээс ирүүлсэн “Зорилтот бүлгийн иргэдийн овог, нэр, гэрийн хаяг, утасны дугаар” бүхий мэдээллийг түүврийн хэмжээнээс хасаж тооцсон.

СУДАЛГААНЫ ЕРӨНХИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Судалгааны мэдээлэл цуглуулах үйл явц нь Нийслэлийн 9 дүүргийн ХХҮХ-ийн удирдлагатай уулзаж, ярилцлага хийх замаар судалгааны мэдээлэл цуглуулах ажлуудыг дараах байдлаар гүйцэтгэсэн. Үүнд:

1. Нийслэлийн 9 дүүргээс 7 дүүргийн ХХҮХ-ээс “Өрхийн амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн иргэд”-ийн мэдээллийг өгсөн.
2. Сонгинохайрхан болон Хан-Уул дүүргийн ХХҮХ-ээс “Өрхийн мэдээллийн нэгдсэн санг удирдах, ашиглах журмын 6 дугаар зүйлд заасан “Мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдал” заалтыг үндэслэн зорилтот бүлгийн мэдээлэл өгөхөөс татгалзсан. (Судалгааны явцад УИХ-ын нөхөн сонгууль нийслэлийн СХД-ийн 28 дугаар тойрогт явагдах болсонтой холбоотойгоор мэдээлэл өгөхөөс татгалзсан.) Иймд бид судалгаагаа цаашид үргэлжлүүлэх зорилгоор тус 2 дүүргийн цагдаагийн Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба, Эргүүл хамгаалалт хариуцсан тасгийн хамт олон болон Эрүүлжүүлэх, саатуулах байрны алба хаагч нарын дэмжлэг туслалцаатайгаар “Зорилтот бүлгийн иргэд”-тэй биечлэн уулзаж, ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлага зохион байгуулж судалгааг авсан.

Судалгааны багийн баримтлан ажилласан зарчмууд:

- “Ковид-19” цар тахалтай холбоотойгоор өөрийн болон бусдын халдвар, хамгааллын дэглэм сахих, урьдчилан сэргийлэх;
- Судалгааны оролцогчдын мэдээллийн нууцлалыг хамгаалах (судалгааны явцад олж авсан аливаа нууц мэдээллийг ямар нэгэн хувь хүн, байгууллагад дамжуулахгүй байх);
- Шинжлэх ухааны үндэстэй, нэгдсэн арга зүйг ашиглах;
- Бүх ойлголт, тодорхойлолтууд нь оролцогч талуудад (тухайлбал, асуулга боловсруулагчид, ярилцлага авагчид, судалгаанд оролцогчид, мэдээлэлд дүн шинжилгээ хийх ажилтнууд) ойлгомжтой байх;
- Цуглуулсан мэдээлэл нь судалгааны зорилгод нийцтэй, үнэн бодитой байх;
- Судалгааны үр дүн, тайлан нь тодорхой, ойлгомжтой, хэрэгцээтэй байх;

1.2. СУДАЛГААНЫ ТҮҮВЭРЛЭЛТ

² Монгол Улсын “Хүн амын амьжиргааны доод түвшин тодорхойлох тухай” хуулийн 3 дугаар зүйлд зааснаар хүн амын амьжиргааны доод түвшин гэж “...хүн амын хэрэглээний доод хэмжээг мөнгөн хэлбэрээр илэрхийлснийг, хэрэглээний доод хэмжээ гэж хүний нэн тэргүүний зайлшгүй хэрэгцээг хангах хүнсний болон хүнсний бус хэрэглээний сагсаар тодорхойлсон бараа, үйлчилгээний шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоосон тоо, хэмжээ”-г ойлгоно.

СУДАЛГААНЫ ХҮРЭЭ:

Улаанбаатар хотын хэмжээнд 2017-2019 оны жилийн эцэст “Амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой иргэд, (регистрийн бүртгэлтэй, тухайн хаягт оршин сууж амьдардаг) өрхөөр судалгааны хүрээг тодорхойлж авч үзсэн. Улмаар, гэрийн хаяг, регистрийн сангийн бүртгэлтэй 4074 өрхийн иргэдийн жагсаалтыг судалгааны түүврийн хүрээ болгон ашигласан.

ТҮҮВРИЙН ХЭМЖЭЭ:


Судалгаанд хамруулах Улаанбаатар хотын хүн амын амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн иргэдийн тоо буюу түүврийн хэмжээг тогтоохдоо дараах алхмуудын дагуу хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Түлхүүр үзүүлэлтийг тодорхойлох (“Зорилтот бүлэг”-ийн өрхийн иргэдийн тоо);
- Түлхүүр үзүүлэлтэд үндэслэн эх олонлогийг тодорхой бүлгүүдэд хуваах; (Шинж чанараар нь буюу судалгаанд оролцох “Зорилтот бүлэг”-ийн өрхийн иргэдийн нас, ам бүлийн тооны их, багаар нь ялган нийт 5 бүлэглэх);
- Хүн амын амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн үзүүлэлтүүдийг судалгаанд оролцсон Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсээс ирүүлсэн мэдээллээр “Нийт ядуу өрхөөс нэн ядуу өрх 43.5 хувийг, Ядуу өрхийн иргэдийн 49.6 хувийг эзэлж байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 0.9-4.6 хувиар өссөн, орон гэргүй ядуу өрхийн 68,3 хувь нь нэн ядуу өрх байгааг судалгаанд харгалзан үзэх;
- “Халамжийн хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг өрхийн эзлэх жинг хамгийн өндөр бүлгийн, өрхийн иргэдээс (энгийн санамсаргүй түүврийн аргаар) 100 хувь судалгаанд хамруулах;
- Үндсэн зорилтот бүлгийн тоонд шаардлагатай түүврийн хэмжээг тогтоох
- Түүврийн хэмжээг Ньюманы тархалтаар хуваарилах;
- Нийслэлийн дүүрэг тус бүрээс энгийн санамсаргүй түүврийн аргаар зорилтот бүлгийн өрхийн иргэдийг сонгох;

Бид нэг шатлалт бүлгийн түүвэр буюу Кластер түүврийг ашиглав. Энэ нь Кластеруудаас түүвэрлэн сонгох, сонгогдсон кластер тус бүрийн бүх нэгжийг судалгаанд хамруулав. Сонгогдсон бүлгийн хүн амын нэгжийн жагсаалтаас мэдээлэл цуглуулж, түүврийн хүрээг уг кластерийн жагсаалт, нийгмийн нэгж, байршлаар тодорхойлов. Энэ тохиолдолд бүлгийн түүврийг ашигласан


1 тохиолдол: дэд хэсэг бүр нэг төрлийн бол – бүлэглэсэн түүвэр хийх нь зохимжтой. [$\rho = 1$]

2 тохиолдол: дэд хэсэг бүр эх олонлогийн нэгжийг ижил хэмжээтэй агуулж байвал – нэг кластерийг судлах нь хүрэлцээтэй. [$\rho = -1/(B-1) < 0$]



бөгөөд түүврийн хэмжээ бага байх тусам стандарт алдаа гарах магадлалтай тул бид

судалгаандаа нийслэлийн дүүрэг тус бүрийн хороо, хэсгийн зорилтот бүлгийг “Эх олонлогт элементүүдийн хүрээ” гэж авч үзсэн. Багцын хэмжээ хэчнээн бага байх тусам эх олонлогийг үнэлж байгаа түүврийн хэмжээ төдий чинээ үнэн зөв байдаг. Иймд багцыг бий болгохдоо багц хоорондын дундаж хэлбэлзэл, мөн хэлбэлзэл нь аль болох бага байхаар тооцоолов.



ХҮСНЭГТ 1. “Зорилтот бүлэг”-ийн өрхийн иргэдийн ам бүлийн тооны бүлгээр, эзлэх хувь.

Бүлэг	Ам бүлийн тоо	Мэдээлэлд хамрагдсан өрхийн тоо	Дүнд эзлэх хувь
1	1-3	281	6,9
2	4-6	2494	61,3
3	7-9	1149	28,2
4	10-12	119	2,9
5	12+ (дээш)	24	0,6
	Бүгд	4067	100%

Дээрх хүснэгтээс харахад 12 ба түүнээс дээш ам бүлтэй өрх нь Нийслэлийн 9 дүүргийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсээс өгсөн “Өрхийн амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн иргэд”-ийн мэдээллийг үндэслэн 4074 өрхийн 12 ба түүнээс дээш ам бүлтэй өрх 0,6% ногдож байна. Харин 4-6 ам бүлтэй өрх хамгийн өндөр хувь буюу 61,4 хувьтай байна.

ХҮСНЭГТ 2. Судалгаанд хамрагдвал зохих өрхийн иргэдийн насны бүлгээр, эзлэх хувь.

Бүлэг	Судалгааны мэдээлэлд	Судалгаанд хамрагдвал	Дүнд эзлэх хувь
-------	----------------------	-----------------------	-----------------

хамрагдсан өрхийн иргэдийн нас		зохих өрхийн тоо	
1	18-28	340 буюу (34.0)	8,4
2	29-38	735 буюу (73.5)	18,1
3	39-48	1835 буюу (183.5)	45,1
4	49-58	619 буюу (61.9)	15,2
5	59 ба түүнээс дээш	538 буюу (53.8)	13,2
	Бүгд	4067 буюу (406.7)	100%

Дээрх хүснэгтээс харвал “Зорилтот бүлэг”-ийн 4067 өрхийн иргэдийн мэдээлэл цугларсан. Бид судалгааны эх олонлогийн дундаж болон стандарт хазайлтыг тооцож гаргах зорилгоор Excel программ дээр хоёртын тооллын системд хөврүүлэхдээ “...буюу” гэж нэрлэсэн.

Одоо дээрх үүсгэсэн бүлгийн дагуу өрхийн тоог авч үзвэл, 39-48 настай иргэдийн 45,1 хувь, 59 ба түүнээс дээш настай иргэд 13,2 хувь, 49-58 настай иргэд 15,2 хувь, 18-28 настай иргэд 8,4 хувь, 29-38 настай иргэд 18,1 хувь тус тус ногдож байна.

1 дүгээр бүлгийн хувьд нийт өрхийн 8,4 хувь ногдож байгаа учраас түүвэрлэлт хийхгүйгээр 100 хувь судалгаанд хамруулахаар төлөвлөсөн. Ингээд нийт авах 0,6 хувь (1 дүгээр хүснэгт бүхий 5 дугаар бүлгийн 24 өрх) -ийг хассаны дараа үлдсэн өрхийн иргэдийн тооны бүлгийн хувьд харьцангуйгаар хэвийн тархалттай гэж үзэн түүврийн хэмжээг тогтоох хэрэгтэй болно.

Түүврийн хэмжээг дараах томъёогоор тооцно.

$$n_{RS} = n_{RS} \{ (z_{(d/2)} \cdot s) / e \}$$

Түүврийн дунджаар эх олонлогийн дунджийг дараах байдлаар үнэлж болох ба үүнийг μ -ийн утга орших итгэмжийн интервал буюу итгэмжийн завсар гэнэ.

Эх олонлогийн дундаж завсарт орших магадлалыг судлаач өөрөө сонгох ба түүнийг боломжийн түвшин α -аар тэмдэглэнэ. $p=1-\alpha$ тоог статистик найдвар буюу итгэх магадлал гэнэ. α , p хоёрын аль нэг нь мэдэгдэж байхад нэг нь нөгөөгөө тодорхойлох ба үүнийг тухайн судлаач өөрөө тогтооно.

Бид үлдсэн бүлгийн түвшинд эх олонлогийн дундаж болон стандарт хазайлтыг тооцоход доорх үр дүн гарна.

ХҮСНЭГТ 3. Өрхийн тоо, иргэдийн насны тоог тусгасан зарим статистик үзүүлэлт

Row labels	Count of	Sun of Судалгаанд хамрагдвал зохих өрхийн тоо	Average of (алдааны хязгаар)	StdDevp of стандарт хазайлт
1	36,1	735 буюу (73.5)	2,0	1,8
2	2,6	340 буюу (34.0)	13,3	2,8
3	2,1	619 буюу (61.9)	30,1	8,4
4	0,8	538 буюу (53.8)	68,3	14,4
Grand Total	41,5	223,2	5,4	11,4

Судалгаанд ихэвчлэн $p=0.95$ буюу 95 хувийн “ач холбогдлын түвшин”-ийг авдаг бөгөөд энэ үед t статистикийн утга 1,96 гэсэн утгыг авдаг. Харьцангуй алдааг 12,4 хувь байна гэж үзвэл бидний таамаглаж байгаа түүврийн алдааны судалгааг 12,4 хувь байна.

Иймд бидний таамаглаж байгаа түүврийн алдааны хязгаар:

$e=0,124*5,4$ (Average)=067 болно.

Ингээд эх олонлогийн стандарт хазайлт $S=11,4$ байна. Одоо тус утгуудыг түүврийн томъёонд оруулан тооцъё.

$$n_{srs} = n_{sRS} \{(z_{(d/2)} \cdot s)/e\} = \{(1.96 * 11.4)/0.67\}^2 = 1122$$

Харин эх олонлогийн дундаж μ ба стандарт хазайлт σ мэдэгдэж байх үед тэдгээрийг ямар боломжийн түвшинд тодорхойлохоо шийдсэний дараа түүврийн хэмжээ n -г дараах байдлаар тооцоолно.

$$\mu = X \pm kS_x = X \pm \sigma / \sqrt{n-1}$$

$$S_x = S / \sqrt{n-1} * \sqrt{N-n} / N-1$$

n - Эх олонлогийн хэмжээ болно. Улмаар $n=678$ болно.

Амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн иргэдийг хүн тус бүрээс нь судалгаа авах боломжгүй гэж үзээд зөвхөн 18-70 хүртэлх насны иргэдийг хамруулах зорилгоор өрх бүрээс төлөөлөх чадвар бүхий нэг иргэнээс судалгаа авахаар сонгосны дараа “ядуу”, “нэн ядуу”, “орон гэргүй” гэх “Зорилтот бүлэг”-ийг оновчтой хуваарилалтын арга гэгдэх Ньюманы хуваарилалтын аргаар өрхийн тооны бүлгүүдэд хуваарилсан.

ХҮСНЭГТ 4. Түүврийн хэмжээг Ньюманы хуваарилалтын аргаар харуулав.

(1)	(2)	(3)	(4)	(5)
Бүлэг	Nh	Sh	Nh+Sh	Neyman-n(h)
1	36,1	1,8	65,7	(73.5) буюу 735 - 429 = 306
2	2,6	2,8	7,1	(34.0) буюу 340 - 194 = 146
3	2,1	8,4	17,2	(61.9) буюу 619 - 497 = 122
4	0,8	14,4	11,4	(53.8) буюу 538 - 434 = 104
Дүн	41,5	11,4	101,3	678

Судалгаанд хамрагдах өрхийн тоонд 18-28 насны 57 иргэд, 59 ба түүнээс дээш насны 89 иргэд буюу нийт 146 хүн 2 дугаар бүлэгт хамаарна.

Бид ач холбогдлын түшинг 95% хэмээн авч үзэж, энэ үед t статистикийн утгыг 1.96 гэж авсан. Бидний таамаглаж байгаа түүврийн алдааны хязгаар $e=0.124*average$ буюу $e=0.124*5.4=0.67$ болно.

Харин эх олонлогийн стандарт хазайлт 11.4 байна. Иймд тус утгуудыг түүврийн томъёонд орлуулан тооцов.

ХҮСНЭГТ 5 Нийслэлийн хүн амын амьжиргааны түвшнээс доогуур орлоготой, судалгаанд хамрагдах өрхийн иргэдийн тоо.

д\д	Судалгааны мэдээлэлд хамрагдсан өрхийн иргэдийн нас	Судалгаанд хамрагдах өрхийн тоо	Дүнд эзлэх хувь
1	18-28	57	8,4
2	29-38	122	18,1
3	39-48	306	45,1
4	49-58	104	15,2
5	59 ба түүнээс дээш	89	13,2

	Бүгд	678	100%
--	-------------	------------	-------------

Ийнхүү өрхийн тооны бүлгүүдэд түүврийн хэмжээг хуваарилсны дараа, бүлэг тус бүрээс энгийн санамсаргүй түүврийн аргаар харгалзах нас, ам бүлийн тоо, иргэдийн тоог сонгож судалгаанд хамруулсан.

1.3. АСУУЛГЫН ХУУДАС

Энэ удаагийн судалгааны үйл ажиллагааг хялбарчлах зорилготойгоор таблет дээр мэдээлэл цуглуулалтыг хийж гүйцэтгэсэн. Мөн асуулгын хуудсыг цаасаар хэвлэн судлаачдад өгөхдөө тус судалгааны хуудсыг өөрчлөхгүй, үрэгдэж, устах эрсдэлээс хамгаалн индексжүүлж, баталгаа гарган тэмдэглэл хөтөлсөн. Мэдээлэл цуглуулалтад таблет ашигласнаар шивэлт хийх шаардлагагүй бөгөөд ингэснээр шивэлтийн техник алдаа гаргахгүй, хугацаа хэмнэх нөхцөлийг бүрдүүлж өгсөн.

Судалгааны асуултын хуудас нь агуулгын хувьд үндсэн 2 хэсэгт хуваагдана. Үүнд:

1. “Амьжиргааны доод төвшнөөс доогуур орлоготой өрхийн иргэд”-ийн ерөнхий мэдээлэл (нийгэм, сэтгэл зүйн онцлог, хүчин зүйлсийг нь харгалзаж судлав.)

2. “Амьжиргааны доод төвшнөөс доогуур орлоготой өрхийн иргэд”-ийн авлигын талаарх ойлголт, хандлагыг тодорхойлох зорилго бүхий хэсэг болно.

Асуулгын бүтэц нь өмнөх жилүүдэд хийгдсэн Авлигатай тэмцэх газрын Судалгаа, шинжилгээний албаны судалгааны асуулгатай адил бөгөөд асуулгын стандарт, асуулгын код, хариултын дараалал, логик уялдаа зэргийг сайтар хангасан.

Судалгааны мэдээлэл цуглуулах үйл ажиллагаа: 2021 оны 7 дугаар сарын 16-аас 9 дүгээр сарын 30-ны өдрүүдэд зохион байгуулсан.

1.4. СУДАЛГААНЫ МЭДЭЭЛ ЦУГЛУУЛАЛТ БОЛОН БОЛОВСРУУЛАЛТ

МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ

Судалгааны мэдээлэл цуглуулалтыг таблет ашиглаж хийж гүйцэтгэсэн. Түүнээс гадна Ковид-19 цар тахал, халдварт өвчний дэгдэлттэй холбоотойгоор халдварын голомт, эрсдэлээс урьдчилан сэргийлж, нэг дор олон хүнийг цуглуулах боломжгүй, давтагдашгүй хүчин зүйл, хорио цээрийн дэглэм зэрэг нөхцөл байдлаас шалтгаалан судалгааны асуултыг хувилан хэвлүүлж, судлаачийн хяналтад респондентоос ярилцлагаар болон утсаар холбогдон судалгаа авсан. Үүнд: Судалгааны мэдээлэл цуглуулах үйл ажиллагааны баталгаажуулалт (фото зураг, аудио бичлэг, аудио бичлэгийн сонсолт, судалгааны оролцогчдын байршлын маршрутын солбицлын тэмдэглэгээ), GPS ашиглан судалгаа авах аяллын замын чиглэлийн баталгаажуулалт хийх, мэдээллийн чанарын баталгаажуулалт (багийн ахлагчийн асуултыг кодлох, ярилцлагыг аудио бичлэгтэй тулгах, шаардлагатай тохиолдолд судалгаанд оролцогчоос тодруулах, засварлах, үйл ажиллагаа) хийх зэргээр ажилласан.

МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТ

Мэдээлэл цуглуулалтыг таблетын тусламжтайгаар хийж гүйцэтгэсэн учраас судалгааны мэдээлэл бүрэн электрон хэлбэрээр үүсэж, нэгтгэгдсэн. Мэдээллийн сан бэлэн болсны дараа үр дүнд шинжилгээ хийх, болон нэгдсэн хүснэгт, үр дүн гаргах зорилгоор мэдээллийн сан (Data)-г кодлов. Үүний тулд Excel программд шивж, дараа нь SPSS-23 программд дуудаж оруулахаас гадна зарим тохиолдолд SPSS программаар асуултуудыг шууд кодлож, хоёртын тооллын системд хөврүүлж байсан.

БҮЛЭГ 2. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

2.1. СУДАЛГААНЫ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Улс орны нийгэм, эдийн засаг, хүн амын сэтгэлгээг ядууруулдаг гол хүчин зүйлсийн нэг нь авлигал билээ. Авлигын судалгааны нэг үндсэн чиглэл нь авлига үүсэхэд нөлөөлдөг хүчин зүйлс, авлигын нийгэм, эдийн засгийн шалтгаан, нөхцөлийг тодорхойлох асуудал байна. Улс орны эдийн засгийн хөгжил, нэг хүнд ногдох орлого ба хөрөнгө оруулалтын хэмжээ бага байх нь авлига үүсэхэд нөлөөлөх гол хүчин зүйл болохыг тодорхойлжээ.³ Онолын хувьд ядуурлын түвшнийг дагаад авлига улам ихэснэ гэж үзэж болно.⁴ Иймд улс орны ядуурлын түвшнийг тодорхойлж, тэдгээрийн нийгэм, сэтгэл зүйн хүчин зүйлсийн талаар судалж, судалгаагаар тогтоогдсон илэрхий дүгнэлт, нотолгоонд дүн шинжилгээ хийж, стратегийн төлөвлөлтөд тусгах нь чухал билээ.

Манай улсад нүүрлээд байгаа “Цар тахал”-ын голомтод хүн амын хамгийн их өртөж байгаа хэсэг нь эмзэг бүлгийн иргэд гэж үзэж болно. Учир нь “Ядуурал эрүүл мэндэд нөлөөлж, эргээд эрүүл мэнд нь ядууралд нөлөөлдөг.” Эдийн засгийн хөгжлөөс шалтгаалан нийгмийн амьдралд давхаргын ялгаа ихсэж, улмаар авлига нэмэгдэх үндэслэл болно.

Дэлхий нийтэд дэгдсэн “Ковид-19” цар тахал манай улсын 2020, 2021 оны статистик үзүүлэлтээр боловсрол, эдийн засаг, эрүүл мэндийн салбарт хүндээр тусаж улам бүр эмзэг бүлгийн өрхийн иргэдийн тоо өсөхөд хүргэж байгаа болно. “Нийслэлд нийт 352,812 өрх байгаагийн 10,629 нэн ядуу өрхөд 44,145 хүн амьдарч байна. Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо 23,826 буюу 7,5%-г эзэлж, нийт өрхийн 2.4% буюу 7,725 өрх 8 ба түүнээс дээш ам бүлтэй, 6,048 өрх 4 ба түүнээс дээш хүүхэдтэй байна⁵.”

Ядуурлын төвшинд нөлөөлж байгаа нэг хүчин зүйл нь нийгмийн хөгжлөөс үүдсэн “орон гэргүй, тэнэмэл” иргэд юм.

Орон гэргүй тэнэмэл иргэдийн хувьд нийгмийн хамгааллын болон бусад нийгмийн үйлчилгээ болох ямар нэгэн тэтгэвэр тэтгэмж, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, тусламжийн гадна үлдэж, оршин суугаа хаяг нь тодорхойгүй байдаг нь зарим нэг эрх мэдэлтнүүдэд “ашиг хонжоо олох, шударга бус байдлыг далимдуулах, авлига хээл хахуул даамжрахад таатай нөхцөлийг бүрдүүлсэн “шуналын сэдэл” бүрдүүлдэг. Учир нь авлига нь нийгмийн үзэгдэл учраас биет бус, субъектив хүчин зүйл юм.

“Хүн амын амьжиргааны түвшин тогтоох судалгаагаар амьжиргааны түвшнээр 1-20 оноогоор үнэлж, 1-2-р үнэлэгдсэн босго оноонд хүрсэн 4074 өрх (нийслэлийн 7 дүүргээс бидний судалгаанд хамруулахаар ХХҮХ-ийн өгсөн мэдээллээр) хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж байна.

Эдгээр өрхийн гишүүд тогтсон ажил, хөдөлмөр эрхэлдэггүй, хүүхдийн мөнгөөр амьдралаа залгуулж байна. Ард иргэдийн дунд “Халамж хавтгайрлаа” гэх яриа байдаг. Тэд дараах нэр төрлийн тэтгэвэр, тэтгэмж авдаг. Тухайлбал:

- Халамжийн тэтгэвэр;
- Нөхцөлт мөнгөн тэтгэмж;

³ Шударга ёс сэтгүүл №19 АТГ-ын МШХ-ийн ахлах мөрдөгч, докторант Н.Тамир “... Mauro, “Corruption and Growth” Quarterly Journal of Economics, Vol 110, August, pp 681-712”

⁴ Шударга ёс сэтгүүл №20 АТГ-ын США-ны ажилтан, комиссар Л.Хангарьд., Авлигын шалтгаан, үр дагавар: Өнгөрсөн арван жилийн эмпирик судалгаанаас ...

⁵ Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2015 оны №200 дугаар тогтоолын үндэслэл.

- Нөхцөлт мөнгөн тусламж;
- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамж үйлчилгээ;
- Хүний хөгжил сангийн хишиг хувь олголт;
- Жирэмсэн, амаржсаны тэтгэмж;
- Алдар цолтой ахмад настны тэтгэмж;
- Алдарт эхийн одонтой эхчүүдийн тусламж;
- Ахмад настны хөнгөлөлт;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөнгөлөлт;
- Бусад сангаас: Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн дагуу Монгол улсын засгийн газрын 2011 оны 134-р тогтоолоор гэх мэт.

Бидний судалгаандаа хамруулахаар цуглуулсан нийт үндсэн нэгжийн тоо нь Улаанбаатар хотын 9 дүүргийн 4'067 өрхийн иргэдийн овог нэр, гэрийн хаяг, утасны дугаар гэх мэт бусад мэдээллийг цуглуулсан. Үүнд:

1. Баянгол дүүрэг 218
2. Налайх дүүрэг 150
3. Багахангай 59
4. Сүхбаатар дүүрэг 643
5. Багануур дүүрэг 259
6. Чингэлтэй 369
7. Баянзүрх 2281
8. Хан-Уул 35
9. Сонгинохайрхан дүүрэг 53 иргэд.

Судалгаанд хамрагдсан нийт 678.

(Судалгаа өгөхөөс татгалзсан 8, утасны дугаар нь холбогдох боломжгүй болон ашиглалтад байхгүй 51 хүн)

Судалгаанд хамрагдсан дээрх иргэдийн 20 гаруй хувь нь (ХУД, СХД) ажил хөдөлмөр эрхэлдэггүй, нийгэмд эзлэх байр суурь, гэр бүлийн харилцаа гэх мэт олон хүчин зүйлсээс шалтгаалж архинд гүн донтдог байна. “Энгийн яриагаар бол архичин, эмнэлгийн хэллэгээр бол архины хамааралтай хүн гэдэг. ДЭМБ-аас архинд донтох эмгэг гэдэг өвчний кодтой, хараат байдалтай, зан үйлийн эмгэг гэж үздэг... Үр дагавар нь бие, сэтгэцийн эрүүл мэндэд муугаар нөлөөлөхөөс гадна нийгэмд аюултай өвчин”.⁶ Ийм хүмүүсийн “тодорхой хэсэг нь нийгэмших, өрхийн амьжиргааны түвшин дээшилнэ... Орон гэргүй, тэнэмэл иргэдийн хувьд нийгмийн хамгааллын болон бусад нийгмийн үйлчилгээ болох ямар нэгэн тэтгэвэр, тэтгэмж, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, тусламжийн гадна үлдэж, оршин суугаа хаяг нь тодорхойгүй шалтгааны улмаас нийгмийн харилцаанаас гадуурхагдаж, хүн байх эрхээ эдлэх боломжгүй байгаагаас гадна тэдгээрийн дан буюу давхар байдлаар үндсэн эрхүүд нь бодитой зөрчигдөж байна”.⁷ Нийслэлийн хүн амын амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрх (эмзэг бүлэг)-ийн иргэдийн дунд “архичид” улам даамжирч, сэтгэцийн эмгэг улам бүр тархаж байна.

“Сэтгэцийн эмгэг”-ийн илрэлийг тодорхойлоход “Гарын тест” зургаар тодорхойлох нь ач холбогдолтой гэж үзэж “эмзэг бүлгийн” иргэдийн Авлигын талаарх төсөөлөл”-д үндэслэж “Гарын тест”-ийн сэтгэл зүйн судалгаа авч, боловсруулсан.


⁶ <https://ikon.mn/opinion/1e0r> "Тархинд нь үүссэн архины голомт жаахан идэвхжихэд л хязгааргүй их уух хүсэл төрдөг"

⁷ <https://www.slideshare.net/ankhbilegluvsan/ss-47548984> “Гэр оронгүй, тэнэмэл, зорилтот бүлгийн иргэдийг нийгэмшүүлэх, хөдөлмөрт бэлтгэх” НХҮХ-ийн мэргэжилтэн М.Ганцэцэг


“ГАРЫН ТЕСТ” СУДАЛГААНЫ ҮР ДҮН

“Гарын тест” судалгаанд хамрагдсан 159 иргэдийн “авлигын талаарх төсөөлөл”-д бичсэн хариултаас харахад дараах байдлаар дүгнэж болохоор байна. Үүнд:

1. Зургийн тайлбар тухайн хүний өөрийн хэрэгцээ, сэдэл, айдас, зөрчлийг илэрхийлэх дэлгэц болдог. Гэхдээ ямар айдас, хүсэл гадааддаа ил байж, ямар нь хэрэгжээгүй байгааг шууд тайлбарлах боломжгүй юм. Гэвч судалгааны явцад “авлига, хээл хахууль” гэх мэт судалгааны асуулгын талаар харилцан ярилцсаны эцэст “авлигатай холбоотойгоор ямар гарыг төсөөлж байна вэ? гэж асуугаад 10 дүрс бүхий гарын зургийг үзүүлж, судлаач тэдгээрийг тодорхойлж нэрлэхийг хүссэн. Ингээд судалгаанд оролцогчийн нэрлэж бичсэн үг тус бүрийг агуулгынх нь хувьд Aff, Com, Der кодолж судална. Түүнчлэн судлаачийн зүгээс “Авлигалжсан үйлдэл гаргахад өдөөгч шалтгааныг гаргахын тулд судалгаанд оролцогч зургийг тайлбарлахдаа тодорхой зан үйлийг илэрхийлж, урьд өмнө тохиолдож байсан үйл явдлуудтай холбож тайлбарлах” сэтгэцийн хоорондын холбоогоор дүгнэнэ.



Зураг 1



Ингэж зан төлөвт дүн шинжилгээ хийсний дараа гаргасан таамаглалуудаар энэхүү “гарын тест”-ийн судалгаанд хамрагдсан хүмүүсийг тодорхойлов. Судалгаанд оролцсон иргэд нь сэтгэл зүйн хувьд далд болгоомжтой, зан үйлийн хувьд идэвхтэй, тодорхой төрлийн зан чанарыг бүрдүүлдэг, хэд хэдэн зуршилтай байв.

2. Зургийн тайлбарт үйл үгийг түлхүү хэрэглэвэл субъектийн хувьд үйлдлийг түлхүү илэрхийлдэг хэмээн дүгнэж болно. Судлаач нь үр дүнг боловсруулахдаа хариултыг ямар үгээр илэрхийлж байгаа анхаарч дүгнэлт гаргадаг. Энэ шинж бүхий судалгаанд хамрагдсан 47 иргэн байна. Эдгээр хүмүүс нь сэтгэл зүйн хувьд үйлдэл, хөдөлгөөн, эрч хүчийг илэрхийлж байна. нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 29,5 % байна.

3. Зургийн тайлбарт нөхөрсөг харилцаа, хамтрахын илрэлийг тодорхойлох Aff, Com, Der үзүүлэлтийн илрэл байхгүй боловч 2-3 Agg хариулт өгөгдсөн хариултууд байгаа тул энэ нь дайсагнасан байдлыг түлхүү тодорхойлно. Ийм хариулт өгсөн, судалгаанд хамрагдсан иргэд 59 байна. Энэ нь нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 37,5 % байна.

д/д	Хариултын нийлбэр оноо	Судалгаанд хамрагдсан Иргэдийн тоо	Дүнд эзлэх хувь	Сэтгэл зүйн байдал
Ядарч, сульдсан, өвчин зовлонд эмзэг, хэт гомдомтгой, идэвх санаачилга бага бүрэг, дуулгавартай хүлцэнгүй. Бусдаар өрөвдүүлэх дуртай... гэх мэт хэв шинжтэй.				
1	10-15	65	40,7%	- Ядарч цуцсан, идэвхгүй, - Сэтгэл санаа муу, өвчин эмгэг зовоосон, судалгаанд оролцох сонирхолгүй.
2		33	21,0%	• Далд болгоомжтой, • Оюун ухааны хөгжил хангалтгүй, • Бусадтай харилцах нийлэмжийн нөөц ядмаг • Амьдралын туршлага бага

Дундаж түвшин буюу Эрч хүчтэй, идэвхтэй, хэв шинж бүхий иргэд				
3	16-25	29	18,6%	• Эвгүй зүйлд зовж шаналах нь бага. • Янз бүрийн нөхцөлд түргэн дасдаг. • Сонирхолгүй зүйлдээ амархан шантардаг. • Бусдыг уриалан зохион байгуулах чадвартай. • Нийтэч уриалгахан шинэ хүмүүсийн дэргэд нэрэлхэж эмээдэггүй.
4	26-40	19	12,3%	Зан үйлийн хувьд идэвхтэй, тодорхой төрлийн зан чанарыг бүрдүүлдэг, хэд хэдэн зуршилтай хослолууд байна.
5	40 -өөс дээш оноотой	13	7,4%	Идэвхтэй, бүтээлч, хэт өндөр идэвхтэй боловч утга учиргүй байдлыг тодорхойлно. Үүнд “Бие хүний завсрын эмгэг”-тэй хүмүүс хамаарч болно. F60.3
	Бүгд:	159	100%	

- Дээрх “гарын тест” судалгааны дүнгээс үзэхэд судалгаанд хамрагдсан 65 иргэн буюу 40,7% нь сэтгэл зүйн хувьд идэвхгүй, ядарч цуцсан, сэтгэл санаа муу, өвчин эмгэг зовоосон, судалгаанд оролцох сонирхолгүй хүмүүс байлаа. Харин судалгааны хамгийн бага хувийг эзэлсэн буюу энэ судалгааны дүнгийн 40 -өөс дээш оноо бүхий 13 иргэн (7,4%) “Бие хүний завсрын эмгэг”-тэй хүмүүс байна. (**F60.3**)

“Бие хүний завсрын эмгэг” F60.3 Энэ нь 2 хэсэгт хуваагдана. Үүнд:

1. Бие хүний сэтгэлийн хөдөлгөөний тогтворгүй эмгэг:
2. Бие хүний огцом уурлах эмгэг

Бие хүний сэтгэлийн хөдөлгөөний тогтворгүй эмгэг: Ийм эмгэгтэй психопатууд сэтгэцийн хувьд маш тогтворгүй байдаг. Тэд өөрийгөө захирч чадахгүй байн байн архидна, хулгай хийнэ, ямар ч бодлогогүй мөнгөө дэмий үрнэ, өөртөө хяналтгүй, бусдын ятгалгад амархан автдаг. Тэд өөрийнхөө эрүүл мэндийн эсрэг ноцтой үйлийг хийдэг.

Бие хүний огцом уурлах эмгэг: Ийм эмгэгтэй психопат өөрийг нь зэмлэж, буруутгахад өөрийгөө хянаж, сэтгэлээ барьж чадахгүй огцом уурлаж, өөрийг нь зэмлэсэн хүнийг хэл амаар доромжлох, зодож бэртээх хэлбэрээр байн байн хүчирхийлэл үйлдэнэ.

Энэ мэт “Нийслэлийн хүн амын амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрийн иргэд”-ийн тодорхой хувийг “бие хүний завсрын эмгэг”-тэй иргэд 7,4% эзэлж байгаа учир эрх баригчид болон засаглах эрх мэдэлгүй иргэдийн эрхийн хэрэгжилт, тэдэнд нийгмээс бүрдүүлж өгч буй боломжуудын хоорондын ялгааг “Авлига” илэрхийлж байна.

“Тэгэхлээр ядуусын авлига ч гэж бий, мөн баячуудын авлига ч байдаг гэсэн үг. Зарим нь улс төрийн эрх мэдлийг мөнгөөр сольдог бол зарим нь мөнгийг улс төрийн эрх мэдлээр сольдог.”⁸ “Шунахай ядуучууд” ба “зэрлэг элитүүд”-ийн дунд орчих вий гэсэн дундаж давхаргынхны болгоомжлолыг сонгуулийн авлигатай холбон тайлбарладаг дискурсууд сонгуулийн ардчиллыг унагаахын төлөөх тэмцэлдээ ашигладаг.”⁹ Авлига нь эрх мэдэл ба хангалуун амьдралд хүрсэн


⁸ Nye, Joseph. “Corruption and Political Development: A Cost-Benefit Analysis”. In: Political Corruption, Heidenheimer and Johnston, p. 286

⁹ Saxer, Marc. “How Thailand’s Middle Class Rage Threatens Democracy”. First published in New Mandala. 21.1.2014, <http://asiapacific.anu.edu.au/newmandala/2014/01/21/middle-class-rage-threatens-democracy/>, accessed 25.4.2014.

хэсэг ба хөрөнгө дээрээ тулгуурлан эрх мэдэлд хүрэхийг эрмэлзэгчид хоорондын ангал дээгүүрх гүүр болж өгдөг. Хотод шинээр шилжиж ирсэн оршин суугчдын хувьд авлигад суурилсан улс төрийн шийдвэр гаргах тогтолцоо илүү хялбар, ойлгомжтой санагддаг нь, мөнгө л байвал овог аймаг, үндэс угсаа гэлгүй засгийн газартай холбож өгдөгтэй нь холбоотой.”¹⁰ гэж Макс Саксер “Өөрчлөлтийн нийгэм дэх авлигатай тэмцэх нь”¹¹ нийтлэлдээ бичжээ.

Анкетын аргаар авсан тоон болон чанарын судалгааны үр дүн

График 1: Судалгаанд оролцогчдын хүйс
Эрэгтэй




Эмэгтэй

Судалгаанд нийт 619 оролцогч хамрагдсанаас 57,2% нь эмэгтэй, 42,8% нь эрэгтэй байна. Судалгаанд оролцогчдын насны хувьд 18-25 (5,1%), 36-45 (31%) насны оролцогчид давамгайлжээ.

График 2: Судалгаанд оролцогчдын нас
18-25 насны иргэд 5,1% 26-35 насны иргэд 27,5%, 36-45 насны иргэд 30,6% 46-55 насны иргэд 19,4% 56 ба түүнээс дээш насны иргэд 17,4% байна.


График 3: Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин



¹⁰ White, Gordon. “Corruption and the Tran sition from Socialism in China”. In: Journ al of Law and Society. Vol. 23, No. 1, p . 149-- 169. Cited in Taube, Markus. “Relational Corruption in the PR China”. In: (Dys)-- functionalities of Corruption, Debiel and Garwich (eds.)

¹¹ <file:///C:/Users/User/Downloads/SaxerKorruptionmongolisch.pdf> Макс Саксер “Өөрчлөлтийн нийгэм дэх авлигатай тэмцэх нь” хуудас 7-35 дэх тал.

График 4: Судалгаанд оролцогчдын хөдөлмөр эрхлэлт 9.0%



Судалгаанд оролцогчдоос харьцангуй өндөр буюу 61% нь бүрэн дунд, 16,9% нь бүрэн бус дунд, дээд боловсролтой нь 11% нь байна. Хөдөлмөр эрхлэлтийн хувьд ажилгүйчүүд 37,5%-ийг эзэлж буй нь нийгэм, сэтгэл зүйн олон шалтгаантай гэж үзэж байна. Тухайлбал: Цар тахал, цалингийн үнэлэмж, (цалингийн хэмжээ) голох, мэргэжлийн тусгай ур чадваргүй зэрэг олон хүчин зүйлс нөлөөлж байна.

II. СУДАЛГААНЫ ДҮН

Асуулт -1. Та дараах байр суурьтай санал нийлж байна уу?

Хүснэгт 2. Авлигын талаарх байр суурь

Авлигын талаарх нийтлэг байр суурь	1.1 Авлига манай улсад нийтлэг үзэгдэл болсон.	1.2 Авлига тодорхой хэмжээнд байхыг хүлээн зөвшөөрнө.	1.3 Хүнд суртлыг шийдвэрлэх арга зам нь авлига өгөх явдал юм.	1.4 Авлига шударга бус дүрэм журмыг тойрч гарахад тусалдаг.
Санал нийлж байна	85,2%	37,1%	33%	45,9%
Огт санал нийлэхгүй	2,8%	48%	54%	27,4%
Мэдэхгүй	12%	14,9%	13%	26,7%

Судалгаанд хамрагсдын 85,2% нь буюу 527 иргэн “Авлига манай улсад нийтлэг үзэгдэл болсон” гэдэгтэй санал нийлж байгаа нь “нийслэлийн хүн амын амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой иргэд” судалгаа өгсөнтэй холбоотой. Учир нь нийслэл хотод амьдардаг учраас тэдэнд амьжиргаагаа дээшлүүлэх, нийгмийн харилцаанд ороход алхам тутамд “шударга бус тохиолдлууд нэлээд байсан” гэж үздэг. Нийслэл хотын алслагдсан дүүрэг болох Багахангай, Багануур зэрэг хүн ам багатай дүүрэгт амьдардаг иргэд уг асуултад хариулахдаа “Авлига харьцангуй бага байдаг” хэмээн үзсэн юм. Энэ дүүргүүд нь харьцангуй хүн ам багатай, бие биеэ таньж мэддэгтэй холбоотой учир ийнхүү хариулжээ.

Хүснэгт 3: Амьжиргааны түвшнээс доогуур орлоготой өрхийн иргэдтэй холбоотой авлигын талаарх нийтлэг байр суурь

Авлигын талаарх нийтлэг байр суурь	Санал нийлж байна		Огт санал нийлэхгүй		Мэдэхгүй		Нийт
	Иргэдийн тоо,	эзлэх хувь	Иргэдийн тоо,	эзлэх хувь	Иргэдийн тоо,	эзлэх хувь	
Авлигаас болж АДТД орлоготой иргэд илүү хохирдог	601	97,2%	0	0	18	2,8	100%
Авлигыг багасгахын тулд иргэд өөрсдөө илүү хариуцлагатай байх ёстой	569	92%	28	4,6%	22	3,4%	100%

Нийгмийн эмзэг бүлгийн иргэд, тэр дундаа “амьжиргааны түвшнээс доогуур орлоготой өрхийн иргэд”-ийн 92 хувь нь “Авлигыг багасгахын тулд иргэд өөрсдөө илүү хариуцлагатай байх ёстой” гэдэгтэй санал нийлж байгаа юм. Бид асуултаа цааш үргэлжлүүлэн, “өөрсдийн оролцоог нэмэгдүүлэх” гэсэн асуудлыг тодотгох зорилгоор “Авлигын талаар мэдээлэл хэлэх үү?, хэн нэгэн бусдад авлига, хээл хахуул өгч, эсвэл авч байвал энэ талаар холбогдох байгууллага хүмүүст мэдээлэх үү?” гэсэн асуултад “үгүй” буюу “мэдээлэхгүй” гэж хариулсан нь бас л дийлэнх хувийг эзэлж байна. “Яагаад авлигын талаар мэдээлэхгүй вэ?” гэж асуухад дараах хариултыг өгсөн. Үүнд:

- “Хүний мууг үзээд яах вэ дээ.”,
- “Хэлсэн нь л ад болно шүү дээ”,
- “Хэл амтай гээд л дахиж бидэнд туслахгүй болчихно”,
- “Зүгээр л мөрөөрөө л байхыг хүсдэг”,
- “Авлига, хээл хахууль өгч байгаа, авч байгаа хүнтэй тааралдаагүй л байна”,
- “Хаана хандахаа мэдэхгүй”,
- “Авлига, хээл хахуулийн талаар хэлсэн хүн л хохирдог”
- “Амьд хүний гэрч болохоор үхсэн хүний дэр бол гэдэг дээ” гэх мэтчилэн хариулт өгөв.

Иймд “өөрсдийн оролцоог нэмэгдүүлэх” гэсэн асуулгад тэд “хувь хүний өөрийн байр сууриас бус харин нийгэмд тогтсон хандлага, эсвэл “хувийн айх, ичих, санаа зовних, өөрт хамаагүй зүйлд оролцохгүй гэсэн амин хувиа хичээсэн...” гэх мэт хандлагаар илэрч байна. Энэ байдал нь “бид авлигаас болж хохирдог” гэсэн ойлголт хэвээр байгааг

илэрхийлнэ. **Асуулт- 2. Таны бодлоор дараах салбаруудаас аль нь авлигад илүү өртсөн бэ?**

	Их өртсөн	Бага өртсөн	Авлигад өртөөгүй	Мэдэхгүй	Нийт
Эрүүл мэнд	96%	2,6%	-	1,4%	100%
Боловсрол	82,3	14,2	-	3,5	100%
Нийгмийн халамж, үйлчилгээ	9,3	22,5	-	68,2	100%
Хорооны ЗД-ын ажлын алба	16,9	4,2	-	78,9	100%
Дүүргийн ЗД-ын ажлын алба	-	7,0	-	93,0	100%
Нийгмийн даатгал	-	1,6	2,1	96,3	100%
Газрын алба	74,9	21,4	-	3,7	100%
Татварын байгууллага	6,8	-	-	93,2	100%
Улсын бүртгэлийн байгууллага	-	9,7	1,9	88,4	100%
Гаалийн байгууллага	46,4	7,6	-	46,0	100%
Мэргэжлийн хяналтын байгууллага	5,7	2,7	-	91,6	100%
Цагдаагийн байгууллага	42,5	14,1	-	43,4	100%
Бусад	-	-	-	-	-

Хүснэгт 4: Авлигад өртөмтгий салбар (хувиар %)

Таны бодлоор дараах салбаруудаас аль нь авлигад илүү өртсөн бэ? гэсэн асуултад “**их өртсөн**”, хэмээн үзсэн хариулт дээр “эмнэлэг, эрүүл мэндийн салбар”, “боловсролын салбар”, “газрын алба” гэж хамгийн их хувь буюу 74,9 – 96 хувь хүртэл үзсэн нь “нийслэлийн хүн амын амьжиргааны түвшнээс доогуур орлоготой өрхийн иргэд” эдгээр салбарт их

үйлчлүүлдэг, нийтлэг ажиглагдсан зүйл нь, амьдралын чанар муугаас болж өвчлөмтгий, бага насны олон хүүхэдтэй зэрэг хүчин зүйлээс шалтгаалан эмнэлэг, сургууль, цэцэрлэгт их ханддаг нь ингэж хариулахад нөлөөлсөн байж болох талтай.

Судалгаанд оролцсон “Амьжиргааны түвшнээс доогуур орлоготой өрхийн иргэд гэмт хэрэг, сахилгын зөрчилд холбогдох, архидан согтууруулах, энэ төрлийн хэрэглээ их байдагтай холбоотойгоор тэдний нийгэмд харьцах хандлагад цагдаагийн байгууллага харилцдаг учраас тус байгууллагыг “авлигад их өртсөн” буюу 42,5% гэж хариулжээ. Ер нь судалгааны явцад “авлига авах, өгөх үзэгдэл маш муу зүйл гэж үздэг учраас өөрийн дургүй, тааламжгүй харьцаатай байсан салбарыг ийнхүү хариулсан байж болох талтай. Харин “татварын алба, гаалийн байгууллага” авлигад их өртсөн гэж хариулсан нь бусдаас сонссон, дуулсан гэж хариулж байгаа нь тэдний авлигын талаарх ойлголт, хандлагыг илэрхийлж байна. Мөн судалгаанд оролцогчдын 74.9% нь газрын алба, 82,3% нь боловсролын салбар, 96% нь эрүүл мэндийн салбарт авлига “маш их” байдаг хэмээн хариулсан байна. Үүнээс үзвэл Эрүүл мэнд, боловсрол, газрын албын салбар нь амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой иргэдэд хамгийн “ээлгүй салбар” гэж хэлж болохоор байна.

Асуулт - 3. Таны бодлоор сүүлийн жилүүдэд авлигын түвшин хэрхэн өөрчлөгдсөн бэ?

График 6: Авлигын түвшний өөрчлөлт

Мэдэхгүй	Буурсан	Өөрчлөгдөөгүй	Өссөн	%
12,7%	1,5	24,6%	61,2%	100

Судалгаанд оролцогчдоос авлигын түвшин сүүлийн жилүүдэд хэрхэн өөрчлөгдөж байгаа талаарх байр суурийг нь сонирхож үзэхэд 61,2% нь өссөн гэсэн бол, 1,5% нь буурсан, 24.6 % өөрчлөгдөөгүй, харин 12.7% мэдэхгүй гэж хариулжээ. Эдгээр хариултаас харахад өмнөх жилд хийгдсэн судалгаанаас ялгаатай буюу иргэдийн байр суурийг илүү тодруулахын тулд авлигын нийтлэг төвшний нөхцөл байдлыг “мэдэхгүй” байж болох иргэдэд сонголт олгосноор бидний энэхүү судалгаанд мэдэхгүй гэсэн хариулт өгсөн оролцогчид 12.7 хувьтай гарсан нь мэдээлэл багатай хэсгийг тогтоох, тодруулан гаргахад арга зүйн ач холбогдолтой болсон гэж үзэж байна.

Сүүлийн 2 жилийн хугацаанд “цар тал”-аас шалтгаалан 2-3 удаагийн бүх нийтийн хөл хорио, хорио цээрийн дэглэм тогтоосон нөхцөл байдлууд нь интернэт, цахим сүлжээгээр

дамжуулан иргэдийн мэдээлэл авах байдал нь маш өндөр болсон, мэдээллийн эерэг сөрөг хандлагад ихээхэн нөлөөлж, “авлига өссөн, эсвэл буурсан” эсэхэд тэд “хяналт, үнэлэмж” тавихгүйгээр “мэдэхгүй” гэх, эсвэл “өссөн, өссөн” гэх хариултууд өгч, иргэдийн хандлагад нөлөөлсөн байна.

Асуулт - 4. Авлигатай тэмцэхийн тулд юу хийх ёстой вэ?

Хүснэгт 5: Авлигатай тэмцэх арга хэмжээний тухай


Хийх зүйлс (1)	Хувь (2)
1. Авах арга хэмжээ, шийтгэлийг хатуу болгох	64,9 %
2. Төрийн байгууллагын үйл ажиллагааг нээлттэй, ил тод байлгах	7,2 %
3. Шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх	2,9 %
4. Олон нийтийг авлигын эсрэг соён гэгээрүүлэх	7,9 %
5. Авлигын эсрэг мэдээллийн нууцлалыг сайжруулах, АТГ-т итгэх итгэлийг нэмэгдүүлэх	3,3%
6. Авлигаас ангид байр суурьтай, улс төрийн нам, нэр дэвшигчийг сонгож санал өгөх нь оновчтой.	5,7 %
7. Бусад (мэдэхгүй)	8.1%
Нийт	100%

Судалгаанд оролцогчдын зүгээс “авлигатай тэмцэхийн тулд авлигын эсрэг авах арга хэмжээ, шийтгэлийг чангатгах шаардлагатай” гэж хамгийн олон буюу 64,9%, бусад буюу мэдэхгүй гэж 8,1% хариулсан байгаа нь энэ чиглэлийн ажилд хариуцлага, хяналт, шийтгэлийн оновчтой тогтолцоо шаардлагатай болохыг, нөгөө талаас “бид үүнийг шийдвэрлэж чадахгүй учраас хариулмааргүй байна, “мэдэхгүй” гэсэн сонголтоор хариулж байна. Улмаар төрийн байгууллагын үйл ажиллагааг нээлттэй, ил тод байлгах (7,2%), шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх (2.9%), олон нийтийг соён гэгээрүүлэх (7,9%), авлигаас ангид байр суурьтай, улс төрийн нам, нэр дэвшигчийг сонгож санал өгөх нь оновчтой (5.7%) ажлуудад нийт судалгаанд оролцогчдын 27% ач холбогдол өгч буйгаа илэрхийлжээ. Ийнхүү авлигын эсрэг хийх ажлуудад нийгэм, улс төр, соён гэгээрүүлэх асуудал харьцангуй өндөр байр суурь эзэлж байгаа нь судалгаанд оролцогчдын 11% нь дээд, 61% нь бүрэн дунд боловсролтой иргэд эзэлж байгаа нь тэдний байр суурийн илэрхийлэл юм.

2.2 АВЛИГАТАЙ ХОЛБООТОЙ ХУВИЙН ТУРШЛАГА

Асуулт - 5. Та өөрт болон гэр бүлд тулгарсан бэрхшээлтэй асуудлаа шийдвэрлүүлж чадахгүй үе тулгарвал хээл хахууль өгөх үү?

График 7: Авлига,Хээл хахууль өгөх эсэх





Авлигатай холбоотой хувийн туршлагыг тодруулах зорилгоор дээрх асуултыг тавихад, тэд бэрхшээлтэй асуудлаа шийдвэрлэхийн тулд ямар ч тохиолдолд хахууль өгөхгүй байж чадна гэж 51,7% саналаа өгсөн нь өмнөх жилийн судалгаанд оролцогчдын байр сууриас ихээхэн ялгаатай буюу ямар ч тохиолдолд хээл хахууль өгөхгүй байж чадна гэсэн хариулт өгч байсан 84.7 хувьтай харьцуулахад буурсан төлөвтэй байгаа нь манай улсын хувьд хахууль өгөхийг тулгах эрсдэлт нөхцөл улам бүр нэмэгдэж буйг харуулж байна. Түүнчлэн судалгаанд оролцогчид “өгөх зүйл” байсан бол өгнө. Өгөх зүйл байхгүй учраас л авлига, хээл хахууль өгөхгүй байгаа юм” гэж гэж хариулж байсан. Нөгөө талаар “авлигад өгөх мөнгөгүй болохоор”, “өгье, гэвч мөнгөгүй” 8%, “өгөх эсэхээ тухайн үедээ л шийднэ дээ” гэж хариулсан иргэд 9% байгаа нь тэдний эргэлзээ, амьжиргааны доод түвшнээс доогуур орлого зэрэг нөхцөл байдалтай нь холбоотой юм.

Асуулт – 5: Та өөрт болон гэр бүлд тулгарсан бэрхшээлтэй асуудлаа шийдвэрлүүлж чадахгүй үе тулгарвал хээл хахууль өгөх үү? гэсэн асуултад “ямар нэг байдлаар өгнө” гэж хариулсан иргэд 35,9% байгаа нь авлигын нөхцөл байдал жилээс жилд хүндэрч, эмзэг бүлгийн иргэдийн хувьд ч энэ нь мэдэгдэхүйц дарамт болж байгааг нотолж байна.

Асуулт - 6. Сүүлийн 12 сарын хугацаанд та болон танай гэр бүлийн гишүүд ямар нэгэн хэлбэрээр хээл хахууль өгсөн үү?

График 8: Сүүлийн 12 сарын хугацаанд хээл хахууль өгсөн эсэх






Сүүлийн 12 сарын хугацаанд хахууль өгсөн эсэхэд судалгаанд оролцогчдын 82.6% нь үгүй гэж хариулжээ. Харин 5,3% нь хахууль өгсөн гэж хариулсан байна.

Судалгаанд оролцогчдоос сүүлийн 12 сарын хугацаанд “хахууль өгсөн” гэж хариулсан иргэд, эмч нарт 51.4%, багш нарт 12.9% нь хэзээ хахууль өгсөн гэж хариулснаас харахад, амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой иргэдийн хувьд хувьд хамгийн их харилцдаг буюу харилцах хэрэгцээ тулгардаг нийгмийн салбар нь боловсрол, эрүүл мэндийн ажилтнууд болох нь харагдаж байна.

График 9: Хэдэн удаа хэзээ хахууль өгсөн

График 9: Хэдэн удаа хэзээ хахууль өгсөн



“Сүүлийн 12 сарын хугацаанд хахууль өгсөн эсэх” гэсэн асуултад “тийм” гэж хариулсан оролцогчдоос “хэдэн удаа өгсөн бэ?” гэж асуухад 62.9% нь 1 удаа, 2-3 удаа 21.4% нь, 15.7% нь 3-аас олон удаа өгсөн хэмээн хариулсан байна.

Авлига, хэзээ хахууль өгч байна гэхээсээ илүү бусдын жишгийг дагаж, өгөх ёстой юм байна хэмээн үзэж, үл ойшоож, алагчилж харьцдагаас асуудлыг өөрт нааштайгаар шийдүүлэх гэж хахууль өгсөн болохоо ийнхүү тэмдэглэсэн байна.

Эндээс харахад хүнд суртал, харилцааны доголдолтой алба хаагчид иргэдэд хүндрэл, чирэгдэл учруулж, асуудлыг түргэн шуурхай шийдвэрлүүлэх зорилгоор, авлига, хахууль өгөх, авах нь ихсэж байна.


Авлигаас үүдэлтэй дарамт амьжиргаагаа залгуулах чадвар сул, “амьжиргааны доод

түвшнээс доогуур орлоготой өрхийн иргэд”, эмзэг бүлгийн ядуу, нэн ядуу, орон гэргүйчүүдийн хувьд “зүй бусаар хахууль өгөх шаардлагатай гэх гаж тогтолцоо” нь тэдний ертөнцийг үзэх үзэлд улам л сөрөг үр дагавар авчирахад хүргэж байна.


Асуулт – 6 (хэрэв хээл хахууль өгч байгаагүй бол асуулт №14-т хариулна уу)

Асуулт - 14. Таны амьдралд “амьжиргааны доод түвшнээс доогуур орлого (АДТДО)-той” учраас ялгаварлагдан авлига, хээл хахуулиар шийдвэрлэх асуудал тулгарч байсан уу?

Судалгаанд оролцогсдын 74,5 % нь өөрсдийнх нь амьдрал, амьжиргаатай нь холбоотойгоор ямар нэг байдлаар ялгаварлагдан гадуурхагдаж байсан боловч авлига, хээл хахуулиар шийдвэрлэх асуудал тулгарч байгаагүй гэж хариулжээ. Энэ нь албан тушаалтнууд АДТДО-той өрхийн иргэдтэй ялгавартайгаар харьцдаг гэж дүгнэж болохоор байна.




- Амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой (хүнсний эрхийн бичигт хамрагддаг) иргэдийн 74,5 хувь нь ялгаварлагдан гадуурхагдаж байсан.
- амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой (орон гэрэгүй, ядуу, нэн ядуу) иргэдийн 25,5% нь ялгаварлагдан гадуурхагдаж байгаагүй.



Асуулт 18: Та нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээнд бүрэн хамрагдсан уу?

График 18: Нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээнд бүрэн хамрагдсан эсэх



Судалгаанд оролцогчдын 11,1% нь нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаагаа илэрхийлсэн бол, 31,3% нь бүрэн хамрагдсан, 58,6% нь ямар нэг байдлаар хамрагдсан гэж хариулсан нь халамж, хамгааллын чиглэлийн ажлын хүртээмж тодорхой төвшинд байна.

Асуулт- 19 Та орлогоо нэмэгдүүлэх талаар ямар бодолтой байдаг вэ? (нээлттэй асуулга)

- “Группт” байдаг тул биеийн байдлыг харгалзаж байж ажил, хөдөлмөр эрхлэх талаар бодож байна. Ажилд орох гэхээр нас харгалзаад ажил олдохгүй байгаа ...гэх мэтчилэн хариулав. (Энэ мэт эрүүл мэнд болон мөнгө, санхүүгийн хараат байдлаас болж орлого олж чадахгүй байгаа талаар, цаашид хэрхэн орлого нэмэгдүүлэх талаар тодорхой зорилгогүй иргэд 28,6% байна.)
- Гэртээ хүүхдээ харж байгаа ..., одоогоор ажилгүй ч ... , улирлын чанартай ажил эрхэлдэг ч ..., мэргэжлийн ажил олдвол ч ... гэх мэт асуудлаар ажил, хөдөлмөр эрхэлж орлогоо нэмэгдүүлэх гэж хариулсан иргэд 61,2% байна.

- Хувиараа хөдөлмөр эрхэлж, төмс ногоо тарих, гутал хувцас оёх гэх мэт аж ахуйн ажил эрхэлж орлогоо нэмэгдүүлнэ гэж 10,2% нь хариулжээ.

Асуулт 20 Танд нийгмийн халамж, хамгааллын дараах үйлчилгээнүүдэд хамрагдахад авлига өгөхөөс өөр аргагүй бэрхшээл тулгарч байсан уу?

- a) Боловсрол, соёл, урлагийн үйлчилгээнд хамрагдахад
- b) Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж авах
- c) Нийгмийн халамжийн тэтгэвэр авах
- d) Нөхцөлт мөнгөн тэтгэмж авах
- e) Олон нийтийн оролцоонд түшиглэсэн хөтөлбөрт хамрагдах
- f) Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдах
- g) Тусламж, хөнгөлөлт эдлэх
- h) Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд хамрагдах
- i) Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах
- j) Бусад....

Судалгаанд оролцогчид дээрх асуулгад хариулахдаа “Нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээнд хамрагдахад янз бүрийн бэрхшээл учирч байсан. Жишээ нь: холбогдох баримт бичгийн бүрдүүлэлт, хэнд хандахаа мэдэхгүй цаг хугацаа алдах, тухайн асуудлаар хөөцөлдөж явах боломж, бололцоо муу, холбогдох мэдээ, мэдээллээс хол байдаг гэх мэт. Гэхдээ тэрхүү бэрхшээлүүдийг даван туулахын тулд авлига өгч байгаагүй гэж 100% хариулжээ. Эндээс үзэхэд амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн иргэд “нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээнд хамрагдахын тулд авлига өгөхөөс өөр аргагүй байдаг” гэжээ.

Асуулт - 21. Та авлигын талаарх мэдээлэл өгч байсан уу, цаашид өгөх үү?

Судалгаанд оролцогчдын 100% нь “үгүй” буюу авлигын талаар мэдээлэл өгч байгаагүй. (“Цаашид ч мэдээлэл өгөхийг хүсэхгүй байна. Тэгж ч хүний мууг үзээд яах вэ дээ... Төрийн алба хаагчид нь ажлаа шударга хийдэг, хүнийг ялгаварлан гадуурхдаггүй, “алагчилж үздэггүй” байгаасай, “адилхан амьдрах гэж байж нэгнийхээ мууг үзээд яах вэ дээ”. “Сургууль, цэцэрлэг, эмнэлэгт өгч буй хэдэн төгрөг бол тэр томчуудын авч байгаа хэдэн зуун сая, хэдэн тэр бум гэгдэх төгрөгийн хажууд бага, өчүүхэн шүү дээ гэж боддог учраас мэдээлэхийг хүсдэггүй.” гэжээ.) Төрийн албан хаагч бүр иргэдийн төлөө гэсэн сэтгэлтэй, хүнлэг чанар, өндөр соёлтой байх үүрэгтэй. Эрхэлж буй ажил, мэргэжлээс хамаарч “болох, болохгүй”-н тухай төсөөлөл төрийн албан хаагч бүрд өөр өөр байна.¹²

Асуулт - 22. Авлигын талаар мэдээлдэггүй шалтгаан нь юу вэ?

- Мэдээллийн нууцлал алдагдахаас эмээдэг 22,7%
- Хаана хандахаа мэддэггүй 23,4%

¹² <http://nda.gov.mn/backend/files/LGIF5c9ZhTAOjAe.pdf> Г.Мягмар, М.Нармандах, Ч.Ундрам “Төрийн алба хаагчийн ёс зүй” АТГ. 2019 он., 3-4 дэх тал

- Авлигатай тэмцэх газарт хэрхэн хандахаа мэддэггүй 24,6%
 - Мэдээлэл өгсөн ч үр дүн нь мэдэгдэхгүй гэж боддог 12,8%
 - Надад ямар ашигтай юм бэ гэж боддог учраас 7,2%
- Бусад 9,3% гэсэн асуултуудад судалгаанд оролцогчид “мэдэхгүй”, маш олон хүчин зүйл нөлөөлнө”, “бүгд л нөлөөлнө” гэх мэтээр хариулсан байна.

Иймд энэ талын мэдээлэл иргэдийн дунд нэн хомс байгаа болох нь харагдаж, соён гэгээрлийн болон ухуулга, сурталчилгааны ажил эрчимтэй зохион байгуулж, иргэдийн хамтын хүчээр хэрэгжүүлэх шаардлага бий болсныг харуулж байна.

Асуулт – 23. Авлига, хээл хахуулийн талаарх мэдээллийг та хаанаас авдаг вэ? (Үндсэн сувгууд)

- 1) Найз нөхөд, гэр бүлийн хүрээнд 11,8%
- 2) Өөрт тохиолдсон туршлага 16,6%
- 3) Хэвлэл мэдээллийн хэрэгслээр 11,2%
- 4) Ам дамжсан ярианаас 35,6%
- 5) Бусад 24,8% гэсэн асуултуудад АТГ-ын сурталчилгаа, телевизор, радиогоор явуулдаг нэвтрүүлэг, дүүргийн нэг цэгийн үйлчилгээнд байрлах сурталчилгааны самбараас гэх мэтээр хариулсан байна.

Авлига, хээл хахуулийн талаарх мэдээллийг ам дамжсан ярианаас (35.6%) олж авдаг, авлигын эсрэг сурталчилгааны ажлыг (24,8%) радио телевизийн болон бусад явуулын сурталчилгааны самбараас олж авдаг байна.

Асуулт - 24. Та Авлигатай холбоотой, авлигын талаарх мэдээллийг хаана, хэрхэн өгөх талаарх дараах сувгуудыг мэдэх үү?

Авлигын талаарх мэдээлэл өгөх мэдлэгийн талаар	Сайн мэднэ	Ер нь мэднэ	Мэдэхгүй	Эзлэх хувь
АТГ-д очиж мэдээлэх	0	4,6%	95,4%	100%
Нийслэлийн "Нэг цэгийн үйлчилгээний төв"-үүдэд байрлах АТГ-ын олон нийтийн төвд хандах	0	46,5%	53,5%	100%
Авлигын эсрэг 110 утсанд мэдээлэх	0	79,1%	20,9	100%

Судалгаанд оролцогсод “авлигын эсрэг 110 утсанд хандах” талаар 79,1% нь, “Нийслэлийн нэг цэгийн үйлчилгээний төвүүдэд байрлах АТГ-ын олон нийтийн төвд хандах” талаар 46,5%, “АТГ-д очиж мэдээлэх” талаар 4,6% нь “ер нь мэднэ” гэж тус тус хариулжээ.

Энэхүү судалгааны дүнг урьд өмнө нь хийгдэж байсан “Авлигатай холбоотой, авлигын талаарх мэдээллийг хаана, хэрхэн өгөх талаар” судалгааны дүнтэй харьцуулахад “ер нь хаана хандахаа мэднэ” хэмээн хариулсан нь 2,8% өссөн байна.

Иймд АТГ-аас зохион байгуулж буй “авлигын эсрэг” сурталчилгааны ажил иргэдэд

тодорхой хэмжээгээр хүрсэн, түүнчлэн Авлига манай улсад өсөж байгаа нь аль нэг байгууллагын үйл ажиллагаатай, тэр дундаа АТГ-ын үйл ажиллагаатай холбоогүй хэмээн дүгнэж болохоор байна.

Тэгэхлээр “амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн иргэд” авлигын талаарх мэдээллийг хаана өгөхөө тодорхой хэмжээгээр мэддэг ч яагаад авлигын талаар мэдээлэл өгч, ханддаггүй талаар асуухад тэд “очиж хандах шаардлага байгаагүй” гэх эсвэл “хариулахаас татгалзах” явдал цөөнгүй байлаа. Иймд энэ бүлгийн иргэдэд чиглэсэн нийгэм, сэтгэлзүйн болон мэдээлэл, соёл, сурталчилгаа, соён гэгээрлийн ажлуудыг зохион байгуулах нь чухал байна.

АСУУЛТ: Та өнөөдрийн энэ амьдралдаа сэтгэл хангалуун байдаг уу? Яагаад...

Судалгаанд оролцогчдын 89,7% нь өнөөдрийн энэ амьдралдаа сэтгэл хангалуун, “болж байна”, “олны жишгээр дажгүй л байна даа”, “манайхаас ч хэцүү айлууд байгаа шүү дээ”, “энэ цар тахлын хүнд үед хэдэн хүүхдүүд маань л эрүүл саруул байвал болно шүү дээ” гэх мэтээр их өөдрөг байсан нь судалгааны багийнхны хувьд ч гайхмаар зүйл байлаа. Бид тэдний амьдралыг хараад яана даа гэсэн бодол төрж байхад “өө болно доо” гэсэн итгэл дийлэнх олонх байсан нь сайхан санагдаж байсан.

Судалгаанд оролцогсдын 7,2% нь хувийн амьдрал ахуйтай холбоотойгоор “Өнөөдрийн амьдралдаа сэтгэл хангалуун бус байгаа” тухайгаа илэрхийлжээ. Тухайлбал: “амьдрал хэцүү л байна.”, “цалин бага байна”, “тэтгэвэр бага байна”, “улирлын чанартай ажил хийдэг, ажил олдохгүй байна”, “групийн мөнгө, хэдэн хүүхдийн мөнгөөр л болгож байна даа, 40 гараад ирэхээр ажил олдохгүй юм аа”, зэрэг хариултуудыг өгсөн байна.

Судалгаанд оролцогсдын 3,1% нь улс орон, нийгэмд чиглэсэн, өргөн хүрээнд асуудлыг авч үзэж, тайлбарласан бөгөөд “өнөөдрийн амьдралдаа сэтгэл хангалуун бус байгаа шалтгаанаа дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- “Шударга бус байдал их байгаа учир өнөөдрийн амьдралдаа яаж ч сэтгэл хангалуун байх вэ дээ”,
- “Авлигыг дээд, томчууд л үйлдэж байгаа шүү дээ. Тэгэхээр бид сэтгэл хангалуун амьдарч чадахгүй байна”,
- “Цар тахал, өвчлөл ихэсчихлээ, удам, генд нөлөөлнө дөө. Хүүхдүүдийн ирээдүйд санаа зовниж байна. Сэтгэл хангалуун амьдрах арга алга” гэх мэт хариулжээ.

Авлига нь ардын ёс заншил, өв уламжлал, ёс суртахууны болон хууль зүйн хүрээнд тогтоогдож хэрэгждэг тул амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн иргэд “ирээдүйдээ итгэлтэй, сэтгэл хангалуун, аз жаргалтай амьдрахад, мөн “шударга ёс тогтсон,

хүн хоорондын тэгш эрх, алагчлалгүй харьцаа”-г хүсэж буйг илэрхийлжээ.

ЧАНАРЫН СУДАЛГААНЫ АРГААР:

Тоон судалгааны асуулга, чиглэлд багтаагүй асуудлаар авлигад өртсөн байж болзошгүй болон авлигатай холбогдож байсан оролцогчдоос дэлгэрэнгүй мэдээлэл авах зорилгоор чанарын судалгааг “фокус бүлгийн ярилцлага” болон ганцаарчилсан ярилцлагын аргаар явууллаа. Судалгааны мэдээлэл цуглуулалтад тухайн оролцогчийн хувийн мэдээллийг хамгаалах үүднээс хөндлөнгийн нөлөөлөлгүй, үнэн бодит мэдээллийг авч судалгаанд ашигласан болно.

Ярилцлагын явцад судалгаанд оролцогч “нийслэлийн амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн иргэд”-ийн онцлог, тухайн дүүргийн оршин суугаа нутаг дэвсгэр, байрлал зэрэг онцлогоос шалтгаалж авлигын асуудал өөр, өөр байна. Гэхдээ нийтлэг байдлаар авлига давтагдаж байгаа салбаруудыг доор жагсааж, холбогдох жишээ, кейсийг хавсарган дүгнэлээ.

1. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРААР:

Улаанбаатар хотын амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой иргэдийн хамгийн их харьцдаг салбар нь эрүүл мэнд, боловсрол, цагдаагийн байгууллага, газрын алба зэрэг салбарууд байдаг нь бидний судалгаагаар нотлогдсон. Эдгээрээс эрүүл мэндийн салбарт хамгийн их ялгаварлагдан гадуурхагдаж байна гэж үзэж байсан. Эмч, сувилагч, болон эмнэлгийн байгууллагын ажилтнууд хамгийн их ялгаварлан гадуурхдаг. Энэ салбарын ажлын ачаалал цар тахалтай холбоотойгоор ихсэж байгаа холбоотойгоос гадна иргэд өөрсдөө авлига, хээл хахуулыг дэмжсэн байдлаар ханддаг нь ч дараах ярилцлага, кейсэд өгүүлэгдэнэ.

Кейс тохиолдлууд:

1. “...Би хүүхдээ төрүүлэхээр 1 дүгээр эмнэлгийн эмчид 300 мянган төгрөг найзаар нь дамжуулан өгч байсан. Би өөрөө БЗД-ийн иргэн учраас харьяаллын бус гээд авдаггүй, манай харьяаллын 3 дугаар төрөх яг үнэндээ үйлчилгээ муутай байдаг... БЗД-ийн 13 дугаар хорооны иргэн А.”
2. “... Саяхан, цар тахлын үеэр болж өгвөл Оросын спутник вакцин тариулчих гээд, 3 дугаар эмнэлэгт шинжилгээ өг, гэхээр нь очтол маш их очертой байсан. Таньдаг эмчдээ хэлтэл 50 мянган төгрөг өгвөл шинжилгээ өгөхөд очер, дугааргүй болно гэсэн. Тэр мөнгийг нь аргалж өгөөд шинжилгээ өгсөн. СХД-ийн 2 дугаар хорооны иргэн Г.”

3. "... 2 сарын өмнө бөөр өвдөөд, эмнэлэгт үзүүлэх гээд цаг автал, 28 хоногийн дараа гэж байгаа юм. Таньдаг сувилагчдаа хэлтэл, ядаж 30 мянган төгрөг өгчих, эмчийг хоолонд орчих гэж хэлээд гуйчихъя гэсэн. Миний бие өвдөөд байгаа болохоор сар шахам хүлээж чадахгүй, хэлсэн мөнгийг нь өгөөд үзүүлсэн дээ. СБД-ийн 7 дугаар хорооны иргэн Ц."

4. "2021 оны 7 сарын сүүлчээр Корона вирус тусчхаад, хороо, дүүргийн эмнэлэг рүү яриад, утсаа авдаггүй. Аргаа бараад яармагийн шинэ эх нялхсын эмнэлэгт **эмчид нь эгчээр нь дамжуулж**, 300 мянган төгрөг өгч хэвтлээ. Гэтэл бүр сүүлд нь, хорооны өрхийн эмнэлгээс ярьж байна лээ. Мөнгөгүй, танил талгүй бол ч үхэх ойрхон болжээ гэж харамсан бодож суулаа. ХУД-ийн 4 дүгээр хорооны иргэн Х."

Дүгнэлт: Авлига нь хувийн, гэр бүл, хамт олны хүлээлтийг биелүүлэх, байгууллага нь албан хаагчийн өөрийн гэр бүл, шашны болон угсаатны бүлэг, нутаг нэгтэн, өмнө хамт ажиллаж байсан хамт олны сонирхлыг илүүд тавих, хүссэн зүйлийг биелүүлэхийг хичээх замаар үүсдэг.

5. "... Манай Багахангай дүүрэг чинь цөөхөн хүн амтай болохоор нэг нэгнийгээ таньж мэддэг, авлигын талаар харьцангуй гайгүй. Энэ хот руу ороод ирэхээр наад авлига гээч юмыг чинь жинхэнэ ойлгож байна. Хэдэн сарын өмнө манай дунд хүү портертэй явж байгаад аварт ороод, гэмтлийн эмнэлэгт хэвтлээ. Ор ч олдохгүй юм гэнэ. Эмчид нь 400 мянган төгрөг өгч хөл, тархиндаа гайгүй оёдол тавиуллаа гэж хүүхдүүд ярьж байна. Хэцүү юм даа хүү минь. Багахангай дүүргийн 2 дугаар хорооны иргэн Т."

6. "Нөхөр бид хоёр 5 хүүхэдтэй. Би төрөхдөө жаахан хүндрэлтэй төрөх гээд байдаг юм. Сүүлийн 3 хүүхдээ 2 дугаар төрөхөд дандаа л мөнгө өгч төрүүлсэн. Хувийн эмнэлэг болохоор өндөр үнэтэй байгаад байдаг юм. Тэрийг нь дийлэхгүй юм аа. Дээр нь төрсний дараа баярлалаа гээд эмч, сувилагч нартаа набор, цэцэг, хоолны мөнгө өгөх нь энүүхэнд шүү дээ. СБД-ийн 17 дугаар хорооны иргэн М."

БОЛОВСРОЛЫН САЛБАРААР:

Амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой иргэдийн хувьд хүүхдийнхээ сургууль, цэцэрлэгийн асуудлаас болж боловсролын салбар дахь авлигатай холбогдох нөхцөл үүсдэг. Хөдөө, орон нутгаас шилжиж ирсэн иргэдийн хүүхдүүдийг дүүргийн бус сургууль, цэцэрлэгт оруулах, шилжүүлэн сургахад тухайн сургууль, цэцэрлэгийн багш, сургалтын менежерүүдэд тодорхой хэмжээгээр мөнгө, бэлэг сэлт, өгдөг нь хэвийн үзэгдэл мэт болсон. Судалгаанд оролцсон эмзэг бүлгийн иргэдийн ихэнх хувь нь хүүхдүүдийнхээ дүрэмт хувцас, ном, сурах бичгийг нь ч худалдан авч чадахгүй байх тохиолдол цөөнгүй байдаг. Үүнээс үүдэлтэйгээр ялгаварлагдан гадуурхагдах, хүүхдүүд цэцэрлэг, сургуульд сурч чадахгүй хичээл таслах, сургууль завсардах тохиолдол гардаг байна. Тухайлбал:

1. "... манай хүүхэд энэ жил 1 дүгээр ангид сургуульд орсон. Харьяаллын дагуу сургуульд нь хүүхдээ оруулахаар очсон. Гэтэл хүмүүсийн дунд 1 дүгээр бүлгийн А бүлэгт хүүхдээ оруулбал сургалт сайтай байдаг. А бүлэгт хүүхдээ оруулахын тулд хахууль, арын хаалга

хэрэгтэй гэсэн. Миний хувьд адилхан л хичээл орох байлгүй дээ гээд хүүхдийн бүртгэлд ач холбогдол өгөөгүй, тэгээд ч тэр А бүлэгт нь оруулахын тулд өгөх бэлэг сэлт, мөнгө байхгүй.

Зарим тохиолдолд, тухайн эмзэг бүлгийн өрхийн иргэд

2. “Хөдөөгөөс шилжиж ирээд БЗД-ийн 16 дугаар хорооллын нэгэн улсын сургуульд хүүхдээ оруулах гэтэл анги дүүрсэн гээд багын менежер нь 600 мянган төгрөг өгч оруулсан шүү дээ. Мөнгө өгвөл анги дүүргэлттэй байсан ч гэсэн хүүхдээ оруулж болдог л юм байна лээ. Нийслэлийн тэргүүний гэхээр нь бас гайгүй сургууль юм болов уу гээд л... БЗД-ийн 19 дүгээр хорооны иргэн Т.”
3. “Хүүхдээ ахлах ангид орох болохоор нь 3, 4 дүгээр хорооллын эцэс рүү гүнзгийрүүлсэн сургалттай Улсын сургуульд оруулчихъя гэтэл ахлахын менежер нь сая төгрөг нэхсэн шүү дээ.”
4. “Манайх орон нутгаас шилжиж ирээд, 10 дугаар ангид орох хүүхдээ СХД-ийн ...-р сургуульд шилжүүлэхээр багштай нь уулзсан, багш нь манайх хөдөөгөөс шилжиж ирсэн хүүхэд авахгүй, анги дүүргэлттэй гэж хэлээд хүүхдийг маань буцаагаад явуулсан байсан. Би өөрөө багштай нь уулзаад, сурлагынх нь дэвтрийг үзүүлж, жаахан бэлэг, дурсгалын зүйл өгсөн. Хүүхэд маань ч сургуульдаа явах болсон.”

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН САЛБАРААР:

Нийслэлийн хүн амын амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн иргэдийн дунд архидан согтуурах болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, мансуурах бодисын хэрэглээ өндөр, нийгэмд гэмт үйлдэл үйлдэх хандлагатай, өвлийн улиралд гудамж талбайд согтуу унтаж гар хөлөө хөлдөөх явдал тохиолддог, дулааны улиралд голын бургас, хогийн цэгүүдэд орогнож хоноглох нь элбэг, бэлгийн замын болон амьсгалын замын сүрьеэ, бусад суурь өвчлөл ихтэй, бусдын ятгалгад амархан ордог, учраас хулгайч, худалч, хулигаан этгээдүүдийн “гар хөл” болж, тэдний санаачилсан “хам хэрэг”-ийг халуун гараараа үйлдэж, хариуцлагыг хүлээх нь элбэг. Хүний үгэнд оромтгой учраас өөрөөс нь овгор этгээд түүнд үүрэг өгвөл гэмт хэрэг үйлдэхэд бэлэн, үе үе огцом уурлах эсвэл гуниг гутралд автаж амиа хорлоход хүрдэг. Тэдний дунд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрх толгойлсон эхчүүд, группт байдаг иргэд, сэтгэцийн эмгэгтэй хүмүүс, орон гэргүйчүүд зонхилон оршино.

Кейс тохиолдол:

“ЧД-ийн 10 дугаар хорооны иргэн У хэлэхдээ: нөхөр нь эрүүлжүүлэхэд орсон, мөнгийг нь өгөөд авах гэтэл хариуцаж байсан цагдаа нь танай нөхөр 2 дахь удаагаа орж байгаа юм байна. 111 рүү ачна, эсвэл 100 мянган төгрөг аваад ир” гэж хэлсэн. Зурагтаа барьцаанд тавиад 100 мянган төгрөг аваад очиход, шууд аваад хармаалчхаж байна лээ. Тэгээд, одоо явж болно гэсэн”

“Транспэрэнси интернэшнл” байгууллага “төрийн албан хаагч төрийн ашиг сонирхолд болон улсын ашиг сонирхолд үйлчлэхээсээ илүү төрийн нэрийн өмнөөс өөрт олгогдсон эрх мэдлээ ашиглаж өөрийн үзэмжээр хувийн ашиг сонирхолдоо үйлчлэх нөхцөл байдлыг ойлгоно¹³ ” хэмээн тодорхойлжээ. Бидний судалгаагаар энэ асуудал батлагдах мэт “судалгаанд оролцогчид” хэрхэн авлига өгч байсан, хэрэгждэг талаар мэдээлэл өгсөн юм.

“Сая шинийн 17-нд хүүхдийн үсний найрт очоод жаахан айраг амсчхаад гарч явтал Дөлгөөн нуурын ар талд цагаан байрны тэнд цагдаа зогсоогоод, согтууруулах ундаа хэрэглэсэн байна, эрх хасна гэхээр нь учраа хэлтэл 200 мянган төгрөг өгчих, гэж байгаа юм. Тэгээд, найз нөхөд рүүгээ залгаж, бөөн юм болж байж, 150 мянган төгрөг өгөөд салсан даа”

¹³ “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” гарын авлага, Улаанбаатар, 2019, 19-р тал

Цагдаагийн алба хаагч хүн шударгаар ажиллаж, амьдрах ганцхан гарц, гаргалгаа байдаг. Шударга байхын эсрэг тал нь шударга бус үйл ажиллагаа байна. Судалгаагаар цагдаагийн алба хаагчийн үйлчлүүлэгчдэд тэгш бус ханддаг, бусдыг чирэгдүүлж, танил тал хардаг зэрэг дутагдлууд их байна. Нөгөө талаар Амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн иргэд асуудалт хүлээцтэй хандах, учир шалтгааныг ойлгох, аливаа төрийн алба хаагчдад хүндэтгэлгүй харьцдаг, сэтгэцийн тулгамдсан асуудалтай зэрэг шинжүүд нь судалгаанд оролцогчдын харьцаа, зан төлөвийн хэв шинжээр нь тодорхойлогдоно.

БУСАД САЛБАРААР:

“Налайх дүүргийн иргэн Ц. Ам бүл 12, бүгд насанд хүрсэн. Тусдаа гарсан ч манай ам бүлийн тоо, харьяалалд бүртгэлтэй байдаг. Налайх дүүргийн ХХҮХ-ээс Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаад нэлээд хэдэн жил болж байна. Бид хэдэн малын буянаар сайхан л амьдарч байна. Хүнсний талон авч байгаадаа ичиж байна аа. Хүнсний талон авч чадахгүй, хэцүү амьдралтай хүмүүс зөндөө байгаа. Халамжийн хэлтсийн хүмүүст хэлж, хүнсний талоноо хасуулна аа. Ойлгож байгаа...”

Нийтийн албан тушаалтан өөрийн чиг үүргээ биелүүлэх явцад өөрийн нь гэр бүл хамаатан садан, хамаарал бүхий хүмүүстээ дэмжлэг үзүүлэх санаа зорилгоор шийдвэр гаргахыг эрмэлзэх байдал мөн л авлига үүсэх нөхцөлийг бүрдүүлж байна. Авлига нь хэдийгээр ажилгүйдэл, эрүүл мэндийн үйлчилгээ хомсдох, өлсгөлөнд нэрвэгдэх зэрэг гунигт явдлыг үүсгэдэг ч ялангуяа зарим улсад соёлын эсхүл уламжлалын нэг хэсэгт тооцогдож хэтэрхий амархан хүлээн зөвшөөрөгддөг хөшингө асуудал юм (Heywood 2015).

Өөрөөр хэлбэл, нэг хүнээс олж мэдсэн зүйлийг нийт хүн амд хамааруулж ойлгоход хэцүү байдаг. Гэвч тухайн хүн яагаад иймэрхүү аашилж байгааг, урьд өмнө тохиолдож байсан үйл явдлуудтай холбож тайлбарласан байх ёстой. Зан үйлийг судлагч шинжлэх ухаануудыг зөв хэрэглэх нь хүн бүрийн ч, бүхэл бүтэн байгууллагын ч үйл ажиллагааны үр дүнг ямагт дээшлүүлдэг гэж үздэг. Иймд “Зан төлөвт дүн шинжилгээ хийсний дараа гаргасан таамаглалууд хүний зан байдлыг тайлбарлаж чадна.

Бид судалгааны тоон болон чанарын шинжилгээний дүнг нэгтгэн авч үзээд, судалгааны үр дүнд “Нийслэлийн хүн амын амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн иргэдийн авлигын талаарх ойлголт, хандлага”-ыг тодорхойлохдоо:

- “Нийгмийн шударга ёс нь улс орны дотоод үйл ажиллагаанд эерэг, чухал нөлөө үзүүлдэг бөгөөд энэ нь зорилтот бүлгийн иргэдийн эрүүл мэнд, орлого, хөдөлмөр эрхлэлт зэрэг гадаад, дотоод хүчин зүйлд нөлөөлөх сэтгэл ханамжаар илэрхийлэгдэнэ.
- Нийгмийн шударга ёс нь нийгмийн хөгжлийн тууштай байдалд төдийлөн нөлөөлдөггүй. Авлигатай тэмцэх ажлын гадаад болон дотоод сэтгэл ханамж нь нийгмийн шударга ёсыг хооронд нь зуучлагчийн үүрэг гүйцэтгэдэг” гэсэн өгөгдлийн боловсруулалтыг Smart PLS 3.0 программ хангамжийн тусламжтайгаар SEM аргыг ашигласан.

Variables	Items	Loadings	Cronbach's Alpha	Composite Reliability	AVE
Organizational justice (OJ)	OJ11	0.716	0.868	0.897	0.523
	OJ13	0.680			
	OJ15	0.733			
	OJ16	0.806			
	OJ17	0.813			
	OJ18	0.808			
	OJ4	0.589			
	OJ9	0.648			
Intrinsic Job Satisfaction (IJS)	JS10	0.773	0.875	0.905	0.571
	JS11	0.807			
	JS2	0.721			
	JS5	0.740			
	JS6	0.738			
	JS8	0.714			
	JS9	0.755			
	JS13	0.790			
	JS14	0.715			
Extrinsic Job Satisfaction (EJS)	JS15	0.764	0.832	0.881	0.597
	JS16	0.427			
	JS17	0.776			
	JS18	0.812			
Organizational Commitment (OC)	OC1	0.785	0.849	0.885	0.526
	OC11	0.688			
	OC12	0.703			
	OC19	0.716			
	OC2	0.784			
	OC20	0.623			
	OC3	0.693			
	OC6	0.731			

Mean	Median	Min	Max	Standard D...	Excess Kurt...
2.343	2.000	1.000	5.000	1.068	0.358
3.686	4.000	2.000	4.000	0.574	2.182
3.743	4.000	2.000	4.000	0.553	3.857
3.629	4.000	2.000	4.000	0.680	1.279
3.657	4.000	2.000	4.000	0.583	1.575
3.771	4.000	3.000	4.000	0.420	-0.188
3.114	3.000	2.000	4.000	0.708	-0.969
3.057	3.000	2.000	4.000	0.715	-1.015
3.114	3.000	2.000	4.000	0.708	-0.969
3.086	3.000	1.000	4.000	0.906	-0.468

Нуугдмал хувьсагч бүрийн үзэл баримтлал бүр нөгөөгөөсөө ялгаатай байхын тулд хийгддэг. Бусад далд бүтэцтэй (Форнелл-Ларкерын шалгуураар) хамаарлын утгаас дээш AVE, үүнд дурдсанчлан бусад үзүүлэлтээс том аливаа үзүүлэлтээс бүх зүйлийн хөндлөн ачааллын утга орно. (5-аас бага бол тухайн загвар нь хоорондоо уялдаа холбоогүй гэсэн үг.)




Figure 2. Model Fit

Авлигатай холбоотой хүчин зүйлсийн хамаарлыг дараах байдлаар тодорхойлж, SPSS программаар variable View-д бүх Data тайлбарыг оруулсан.

- Авлигын эсрэг авах арга хэмжээ, хийгдэх ажил (Work:1-7)
- Арга барил, хандлага (Approach:1-5)
- Сэтгэл ханамж (Satisfaction: 1-5)
- Эрүүл мэнд (Health: 1-8)

D	E	F	G	H	I	J	K	L	M	N	O	P	Q	R	S	T	U	V
Work -4	Work -5	Work -6	Work -7	Work -8	авлигын э	арга бари	Approach-	Approach-	Approach-	сэтгэл хан	Satisfactio	Satisfactio	Satisfactio	Satisfactio	эрүүл мэн	эрүүл мэн	Health-3	Health-4
3	3	3	3	3	4	4	4	4	4	4	4	4	4	4	5	3	3	3
3	2	3	2	2	4	4	4	4	4	2	2	2	2	2	3	2	5	2
1	1	1	1	1	4	4	4	4	4	3	3	3	3	3	2	2	2	2
1	1	1	1	1	4	4	4	4	4	4	4	4	4	4	3	3	3	3
1	1	1	1	1	4	4	4	4	4	4	4	4	4	4	5	5	5	5
3	3	3	3	3	3	3	3	3	4	3	3	3	3	3	3	2	2	2
2	2	2	2	2	4	4	4	4	4	4	4	4	4	4	4	4	4	3
1	1	2	2	2	3	3	3	3	3	3	2	3	3	3	3	3	5	5
3	3	3	3	3	4	4	4	4	4	3	3	3	4	4	3	3	5	2
3	3	3	2	1	4	4	4	4	4	4	4	4	4	4	3	3	3	

Мөн Excel дээр шивэгдсэн дата-г SPSS-23 программд болон Smart PLS 3.0 программд байршуулав.

Судалгааны нэгдсэн мэдээллээс хамгийн их тоон илэрхийлэл бүхий хүчин зүйлсийн хоорондын хамаарлаар авч үзвэл: Амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн иргэдийн авлигын талаарх ойлголт нь “нийгмийн шударга ёс, түүнчлэн өөрт нь тохиолдсон тодорхой нэг зүйлд шударга ёсны талаарх иргэдийн ойлголтоор тодорхойлогддог байна.

Судалгаанд оролцох өрхийн иргэдийн мэдээлэл өгсөн Нийслэлийн 7 дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсээс явуулж буй үйл ажиллагаа нь “Амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн иргэд”-эд шударга ёсыг харуулдаг. Учир нь хүнсний эрхийн бичгээр амьжиргаагаа залгуулдаг иргэд сүм хийд, буяны байгууллагад хандаж үйлчилгээ авдаг байсан нь “ёс суртахуун, шашин шүтлэг, эсвэл хуулийн хэм хэмжээний дагуу иргэдийг агуу ёс суртахууны үүднээс авч үзэх (Гринберг, 1990)” тэдний “Авлига”-ын талаарх ойлголтод хамаарч, тэдний зан үйлээр илэрхийлэгддэг байна.

Нийслэлийн дүүрэг, хороо, хэсгийн ахлагч нарын амлалт, тэдний ажилд оролцох оролцоо нь шударга ёсыг нааштай хүлээн авахын тулд иргэдийн “авлига-шударга ёсны талаарх сэтгэл ханамж, арга барил-хандлага нь тодорхой хүний өөрийн гэсэн үнэлгээний үр дүнгээр илэрхийлэгдэнэ. Шударга ёсны үзүүлэлт нь дараах зүйлсээр илэрхийлэгдэнэ. Үүнд:

- Хуваарилалтын шударга ёсны үзүүлэлт;
- Процедурын шударга ёсны үзүүлэлт;
- Харилцан үйлчлэлийн шударга ёсны үзүүлэлт;

НАЙДВАРТАЙ БАЙДАЛ,

Variables	EJS	IJS	OC
Extrinsic Job Satisfaction (EJS)			2.266
Intrinsic Job Satisfaction (IJS)			2.085
Organizational Commitment (OC)			
Organizational justice (OJ)	1.000	1.000	2.276

Discriminant Validity Test

Дээрх тайлбарласнаар “Амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн иргэд”-д хандсан аливаа “улс төрийн амлалт” нь тухайн иргэдийн дүр төрхийг бий болгодог бөгөөд тэдний өмнө иргэдийн өрхийн орлогоо нэмэгдүүлэх хүсэл, хэрэгцээ, хариуцлагыг илэрхийлэх хандлагатай байна.

ДҮГНЭЛТ

Монгол улсын Авлигын эсрэг хуулийн 4-р бүлгийн 18.1.3-т заасан заалтын хэрэгжилтийн хүрээнд Нийслэлийн хүн амын дундаас зорилтот бүлэг болох амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн иргэдийн дундах авлигын талаарх ойлголт, хандлагыг тодорхойлох судалгааг хийх, мэдээллийн санг шинэчлэх зорилтын хүрээнд Авлигатай тэмцэх газартай

Дэлгэрэнгүй хууль ТББ тус судалгааг хамтран зохион байгууллаа.

Судалгаанд хамрагдах зорилтот бүлгийн онцлог буюу амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой иргэдийн оршин амьдрах нөхцөл болон цаг үеийн байдлаас уялдаж судалгааг нийслэлийн 9 дүүргийн иргэдээс түүвэрчлэн, уулзах, харилцаа холбооны хэрэгслээр холбогдох аргуудаар судалгаанд хамруулав. Тус судалгааны ажил нь мөн Ковид-19 цар тахлын ид өрнөлийн үед хэрэгжсэнээрээ нэг талаас судалгааны багын ажлын ачаалал, хүртээмжтэй байдалд нөлөөлснөөс гадна бас судалгааны зорилтот бүлэг болох амьжиргааны түвшнээс доогуур орлоготой иргэд тус цар тахлын эдийн засгийн сөрөг үр дагаварт илүү өртөж, доройтсон үетэй давхацсан байснаараа онцлог боллоо. Энэхүү судалгаанд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

✚ Монгол улс ковид-19 цар тахалтай тэмцэх буй энэ үед тус судалгааны ажил хийгдэж, инфляц өмнөх онуудаас өндөр байгаа нь бүх төрлийн бараа бүтээгдэхүүний үнийн өсөлттэй холбоотой билээ. Үүнтэй холбоотойгоор амьжиргааны баталгаажих түвшин доогуур иргэдийн амьжиргаанд үнийн өсөлтийн дарамт нүүрлэсэн нь тэдний авлигын талаарх ойлголт, байр суурьд нөлөөлж байна. Өөрөөр хэлбэл Хүн амын амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн иргэдийн амьдрал улам бүр хүнд бэрх болж байгаа нь авлигатай холбоотой гэж үзэж байна.

✚ Тус судалгааны тоон үр дүнгээс үзэхэд “авлига манай улсад нийтлэг үзэгдэл болсон”, “авлига аливаа асуудлыг амар хялбар шийдэх гарц болдог нь үнэн” мөн “сүүлийн жилүүдэд авлигын түвшин өссөн” гэж дийлэнх олонх үзсэнээс дүгнэхэд, авлига зорилтот бүлгийн дунд түгээмэл болсныг илтгэж байна.

✚ Таны бодлоор дараах салбаруудаас аль нь авлигад илүү өртсөн бэ? гэсэн асуултад “их өртсөн” хэмээн үзсэн хариулт дээр “эрүүл мэндийн салбар”, “боловсролын салбар”, “газрын алба” гэсэн төрийн үйлчилгээний байгууллагууд хамгийн их хувь буюу 74,9–96 хувь хүртэл үзсэн нь эдгээр салбарт их үйлчлүүлдэг, мөн амьдралын чанар муугаас болж өвчлөмтгий, бага насны олон хүүхэдтэй зэрэг хүчин зүйлээс шалтгаалан эмнэлэг, сургууль, цэцэрлэг зэрэг төрийн үйлчилгээний байгууллагуудаар түгээмэл үйлчлүүлдэг нь ийнхүү хариулахад нөлөөлсөн байж болох талтай.

✚ Хүн амын амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн иргэдийн дийлэнх олонх нь иргэд илүү хариуцлагатай байснаар авлига буурна гэж үзсэн боловч өөрсдөө хариуцлага хүлээхгүй, “авлигын мэдээлэл огт өгөхгүй”, “авлигын гэмт хэрэгт авах арга хэмжээ, шийтгэлийг хатуу болгох нь авлигатай тэмцэнэ” гэснээс үзэхэд судалгааны зорилтот бүлгийнхэн авлигын эсрэг тэмцэлд оруулах хувь нэмэр, үүрэг хариуцлага, үр дагаврын талаар ойлголт, мэдлэг, мэдээлэл багатай болох нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл, авлигыг бууруулахад тэдний идэвх, оролцооноос шалтгаалахгүй төдийгүй “ихэвчлэн нийгмийн өндөр орлоготой хэсгийнхний дунд байдаг үзэгдэл” мэтээр ханддаг байна.

✚ Авлигад хандах хандлага, туршлагыг тодруулахад тэдний ихэнх нь сүүлийн 1 жилийн хугацаанд хэн нэгэнд хээл хахууль өгөөгүй бөгөөд нөгөө талаар “авлигад өгөх мөнгө байхгүй учраас” хахууль өгөхгүй гэсэн зарим оролцогчдын хариулт нь бидний анхаарлыг их татлаа. Үүнээс харвал тэдний ихэнх нь амьжиргааны доод төвшнөөс шалтгаалж ямар ч тохиолдолд авлигал өгөхгүй бөгөөд хэрвээ амьдралын боломж нь нэмэгдвэл шаардлагатай тохиолдолд авлигал өгөх болно гэсэн дүгнэлт хийхэд хүргэж байна.

✚ Хүн амын амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн иргэдийн дунд хийсэн чанарын судалгааны явцад тулгарсан бодитой үйл явдлуудаас харахад, олонх нь өөрсдийн амьдрал, амьжиргаатай холбоотой ямар нэг байдлаар ялгаварлагдан

гадуурхагдах, суурь эрх, эрх чөлөөгөө эдэлж чадахгүй байх, үл ойшоогдох тохиолдол байнга гардаг бөгөөд энэхүү нийгмийн сүүдэр нь тэднийг ямар нэг байдлаар авлигал өгөхөөс өөр аргагүй байдалд хүргэдэг байж болох талтай юм.

✚ Хүн амын амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн иргэд авлигын аливаа хэлбэрт өртөх эсвэл гэрч болсон тохиолдолд энэ талаар холбогдох байгууллага албан тушаалтанд мэдээлэх огт хүсэлгүй болох нь судалгаагаар тодорхойлогдсон болно.

✚ Нийслэлийн хүн амын амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрх (эмзэг бүлэг)-ийн иргэдийн дунд “архичид” улам ихсэж, сэтгэцийн эмгэг улам бүр тархаж байна. Судлаачийн зүгээс “Авлигалжсан үйлдэл гаргахад өдөөгч шалтгааныг гаргахын тулд судалгаанд оролцогч зургийг тайлбарлахдаа тодорхой зан үйлийг илэрхийлж, урьд өмнө тохиолдож байсан үйл явдлуудтай холбож тайлбарлах” сэтгэцийн хоорондын холбоогоор дүгнэхэд “гарын тест”-ийн судалгаанд хамрагдсан хүмүүс сэтгэл зүйн хувьд далд болгоомжтой, зан үйлийн хувьд идэвхтэй, тодорхой төрлийн зан чанарыг бүрдүүлдэг байгаа бөгөөд “бие хүний завсрын эмгэг”-тэй иргэд 7,4% эзэлж байгаа, энэ мэт ядуу иргэдийн “бие хүний завсрын эмгэг”, болон нийгэм, сэтгэл зүйн хандлага бусад шалтгаанаар “Эрх баригчид болон засаглах эрх мэдэлгүй иргэд”-ийн эрхийн хэрэгжилт, тэдэнд нийгмээс бүрдүүлж өгч буй боломжуудын хоорондын ялгааг “Авлига” илэрхийлж байна. “Тэгэхлээр ядуусын авлига ч гэж бий, мөн баячуудын авлига ч байдаг гэсэн үг.

✚ Хүнсний эрхийн бичгээр амьжиргаагаа залгуулдаг иргэд сүм хийд, буяны байгууллагад хандаж үйлчилгээ авдаг байсан нь “ёс суртахуун, шашин шүтлэг, эсвэл хуулийн хэм хэмжээний дагуу иргэдийг агуу ёс суртахууны үүднээс авч үзэх (Гринберг, 1990)” тэдний “Авлига”-ын талаарх ойлголтод хамаарч, тэдний зан үйлээр илэрхийлэгддэг байна.

✚ Амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн иргэд”-д хандсан аливаа “улс төрийн амлалт” нь тухайн иргэдийн дүр төрхийг бий болгодог бөгөөд тэдний өмнө иргэдийн өрхийн орлогоо нэмэгдүүлэх хүсэл, хэрэгцээ, хариуцлагыг илэрхийлэх хандлагатай байна.

ЗӨВЛӨМЖ

1. Эдийн засгийн нөхцөл байдал буюу амьжиргааны түвшнээс хамааран ялгаварлан гадуурхагдах явдлын эсрэг Хүний эрхийн түгээмэл тунхаглалд “хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна улмаар хүн бүр энэ тунхаглалд заасан бүхий л эрх, эрх чөлөөг...үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлын ялгааг эс харгалзан ямар ч гадуурхалгүйгээр эдлэх ёстой¹⁴” гэж заасан байдаг. Ядуурлыг бууруулах олон улсын төдийгүй дотоодын түвшинд олон хөтөлбөр төслүүд хэрэгжүүлсээр ирсэн боловч тус судалгааны үр дүнд эдийн засгийн аливаа төсөл хөтөлбөрийг иргэний эрхийн хөтөлбөрүүдтэй хамтатган хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.

НҮБ-ын ядуурлын эсрэг төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллага, төрийн байгууллагууд, орон нутгийн засаг захиргааны нэгжүүд болон Авлигатай тэмцэх газар, Орон нутгийн засаг захиргааны нэгжүүдтэй хамтран ажиллах хэрэгцээ олон нийтийн байгууллагуудын хамтын ажиллагааг уялдуулах шаардлагатай.

2. Хүн амын амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн иргэд эдийн засгийн боломж бололцооныхоо хувьд хамгийн доод түвшинд байдаг. Тиймээс үл хайхрагдах, гадуурхагдах гэмт үйлдлийн байнгын хохирогч болох эрсдэлд байдаг учир тухайн иргэдийг тодорхойлон бүртгэгч, шууд байдлаар харьцаж ажилладаг засаг захиргааны нэгжүүдийн

¹⁴ [Universal Declaration of Human Rights | United Nations](#)

ажилтан албан хаагч, удирдлагуудад Авлигатай тэмцэх газраас сургалт мэдээллийг тогтмол явуулж, таниулан сурталчлах ажлыг эрхлэн явуулах.

3. Хүн амын амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн иргэд нь орон гэргүй, холбогдох хаяггүй, хүнд өвчтэй, оршин суугаа тодорхой газаргүй байх зэрэг эдийн засгийн хамгийн наад захын хэрэгцээ шаардлагаа хангаж чаддаггүйн улмаас авлигын гэмт хэргийн гэрч, хохирогч болсон ч мэдээлдэггүй, хайхардаггүй, өөрсдийг нь ялгаварлан гадуурхах байдалтай эвлэрсэн байдаг гэх мэт онцлог талыг нь анхааран үзэж тухайн авлигын талаарх ойлголт, хандлагыг сайжруулах, мэдээллээр хангах, тухайлсан кэйс дээр туслан ажиллах боломжтой иргэний нийгмийн байгууллагуудад Авлигатай тэмцэх газраас арга зүй, техникийн аливаа шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлэх.

4. Тус зорилтот бүлгийн хэрэгцээ шаардлагад нь таарсан арга замаар мэдлэг, мэдээлэл олгох, соён гэгээрүүлэх ажлыг засаг захиргааны нэгж, цагдаагийн байгууллага, эмнэлгийн байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудтай үйл ажиллагаагаа уялдуулан зохион байгуулах.

5. Хүн амын амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн иргэдэд тулгарах бэрхшээл, ялгаварлан гадуурхалтын талаар нийгэмд зөв ойлголт түгээх, тэдгээр иргэдтэй харилцах хандлагыг эерэг болгох, эдийн засгийн хүндрэлтэй байдлаас улбаалан бий болсон аливаа сөрөг үр дагавраар нь алагчлалгүй хүн гэдэг үүднээс нь хүндэтгэлтэй харилцах, эерэг хандлагыг бий болгох хөтөлбөр арга хэмжээг Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж иргэдийн хандлагыг эерэг болгох, халамжлах, анхаарал тавихад тустай хөтөлбөрүүд хэрэгжүүлэх.

6. Төрийн захиргаа, үйлчилгээний байгууллагуудад төдийгүй олон нийтэд чиглэсэн Авлигын тухай соён гэгээрүүлэх болон авлигын эсрэг арга хэмжээнүүддээ хүн амын амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн иргэдийн эдийн засгийн нөхцөл байдлаас нь улбаатай бий болдог хүндрэлүүд, бэрхшээлүүдийн талаар мэдлэг мэдээллийг хамтатган олгох, Хүн амын амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн иргэдийн эрх ашгийг хамгаалсан аливаа гуравдагч этгээд, иргэний нийгмийн байгууллагуудыг урамшуулан дэмжиж ажиллах.